



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2021 оны Б/08 дугаартай “Албан үүрэг түр орлон гүйцэтгүүлэх тухай” тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын /НАГ 2021/86-ШТА-ГА/ тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу мэдэгдэхийг Баянгол дүүргийн Засаг дарга /Ө.Сумьяабаатар/, Баянзүрх дүүргийн Засаг дарга /Н.Баярмөнх/, Багануур дүүргийн Засаг дарга /С.Даваасүрэн/, Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга /Н.Алтаншагай/, Сүхбаатар дүүргийн Засаг дарга /Х.Болормаа/, Хан-Уул дүүргийн Засаг дарга /Ж.Алдаржавхлан/, Чингэлтэй дүүргийн Засаг дарга /Н.Батсүмбэрэл/-д тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Аудитын гуравдугаар хэлтэс /Э.Мөнхмандах/-т үүрэг болгосугай

4. Тайланг Баянгол, Баянзүрх, Багануур, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАХ-г батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны хариуцлагагүйгээс төсвийн хөрөнгө арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулагдах нөхцөлийг бий болгож байна.



АУДИТЫН СЭДЭВ: ДҮҮРГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

Улаанбаатар хот
2021 он

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	2
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	3
Аудитын 3 дугаар хэлтсийн дарга, аудитын менежер:	Хавсралтын жагсаалт	3
 Э.Мөнхмандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Аудитын менежер:	Ерөнхий мэдээлэл	5-6
 Л.Саранбаатар		
Аудитор:	Бүлэг 1. Хуулийн шаардлагад нийцүүлэн тах-г төлөвлөж батлуулсан эсэх	7-9
 Г.Чулуунцэцэг		
Гэрээт ажилтан:	3.Баярбилэгт Бүлэг 2. Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх	9-15
 Б.Номин		
	Бүлэг 3. ТАХ-ний санхүүжилт болон хэрэгжилт нь үр нөлөөтэй, үр дүнтэй байсан эсэх	15-23
	Аудитын дүгнэлт	24
	Аудитын зөвлөмж	25
	Холбогдох байгууллагын санал	26-27
	Нийслэл дэх Төрийн аудитын газрын тайлбар	28
	Хавсралтууд	29-49

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 327787

Тайланг НТАГ-ын <http://www.audit.mn/> веб сайтаас үзнэ үү.

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БТХ	Бодлого төлөвлөлтийн хэлтэс
ДБТХ	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид
НАЗХГ	Нийслэлийн авто замын хөгжлийн газар
НД	Налайх дүүрэг
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭЗТХ	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	2019, 2020 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ	5
Хүснэгт 2	Дүүргүүдийн ИТХ-аар баталсан ТАХ	7
Хүснэгт 3	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаагүй ТАХ	8
Хүснэгт 4	Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ	8
Хүснэгт 5	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ	9
Хүснэгт 6	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам	10
Хүснэгт 7	Шууд худалдан авах гэрээ байгуулсан ТАХ	10
Хүснэгт 8	Тендерийн баримт бичигт заасан нөхцөл хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан	13
Хүснэгт 9	2018-2020 онд шалгуур хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан ТАХ-ний тоо	14
Хүснэгт 10	ТАХ-ний хэрэгжилтийн судалгаа	15
Хүснэгт 11	Аудитын түүвэрт хамрагдсан ТАХ	16
Хүснэгт 12	Захиалагчийн хяналтын зардалд олгосон санхүүжилт	19
Хүснэгт 13	ТАХ-ний санхүүжилтийн судалгаа	20
Хүснэгт 14	2019, 2020 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги	20
Хүснэгт 15	Гэрээний хугацаа хэтэрсэн ТАХ-ний хоногийн тооцоо	21
Хүснэгт 16	Хөрөнгийн бүртгэлийн судалгаа	21
Хүснэгт 17	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт	22

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаагүй ТАХ	29-37
Хавсралт 2	Зураг төсөвгүй болон зураг төсвийг хугацаанд батлуулаагүй ТАХ	38
Хавсралт 3	ХАА зохион байгуулахад үйл ажиллагаатай холбоотой гарсан зөрчил	38-45
Хавсралт 4	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой гарсан зөрчил	45-49

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд НТАГ-аас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Аудитын зорилт Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:
Аудитын хамарсан хүрээ	 Хуулийн шаардлагад нийцүүлэн ТАХ-г төлөвлөж батлуулсан эсэх  ХАА-г хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх  ТАХ-ний санхүүжилт болон хэрэгжилт нь үр нөлөөтэй, үр ашигтай байсан эсэх
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг дүүргүүдийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэс, Дэд бүтэц, тохижилтын хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба, “НХОГ” ОНӨААТҮГ, СХД-ийн захиалагчийн алба ОНӨААТҮГ, “Алтай Рөүд”, “Алтан дуулга” ХХК-ийг хамруулан гүйцэтгэлээ. Аудитыг АДБООУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг 3 дугаар хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, аудитор Г.Чулуунцэцэг ахалж, аудитор З.Баярбилэгт, Б.Номин нар гүйцэтгэв. Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хэрэгжүүлэв. Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр батлуулж аудитыг эхлүүлсэн ч “Covid 19” цар тахлын үеийн хөл хорио, “1 хаалга 1 шинжилгээ” аудит хийгдсэн зэргээс шалтгаалан 2 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн гүйцэтгэлийн үе шатны ажлыг эхлүүлж, 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдрөөс талбарт ажиллаж эхэлсэн. Талбарын үе шат 30 хоног үргэлжилсэн. Төлөвлөгөөний дагуу СБД-т 2021 оны 4 дүгээр сарын 05-аас 16-ны хооронд ажиллах байсан ч тус дүүргийн Тамгын газарт цар тахал гарсан, 2021 оны 4 дүгээр сарын 10-аас бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн зэрэгтэй холбоотойгоор тус дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжсэн ТАХ-г аудитад хамруулах цаг хугацаа байгаагүй болно. Иймд НТАГ-ын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын шийдвэрээр аудитын хугацааг 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр хүртэл ажлын 10 хоног сунгасан. Мөн цар тахлын үеийн дэглэмтэй холбоотойгоор БНД, НД, БХД-т хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтийг газар дээр нь тулган баталгаажуулах боломжгүй байсан.
Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл	Аудитыг 3 дугаар хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, аудитор Г.Чулуунцэцэг ахалж, аудитор З.Баярбилэгт, Б.Номин нар гүйцэтгэв. Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хэрэгжүүлэв. Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр батлуулж аудитыг эхлүүлсэн ч “Covid 19” цар тахлын үеийн хөл хорио, “1 хаалга 1 шинжилгээ” аудит хийгдсэн зэргээс шалтгаалан 2 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн гүйцэтгэлийн үе шатны ажлыг эхлүүлж, 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдрөөс талбарт ажиллаж эхэлсэн. Талбарын үе шат 30 хоног үргэлжилсэн. Төлөвлөгөөний дагуу СБД-т 2021 оны 4 дүгээр сарын 05-аас 16-ны хооронд ажиллах байсан ч тус дүүргийн Тамгын газарт цар тахал гарсан, 2021 оны 4 дүгээр сарын 10-аас бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн зэрэгтэй холбоотойгоор тус дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжсэн ТАХ-г аудитад хамруулах цаг хугацаа байгаагүй болно. Иймд НТАГ-ын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын шийдвэрээр аудитын хугацааг 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр хүртэл ажлын 10 хоног сунгасан. Мөн цар тахлын үеийн дэглэмтэй холбоотойгоор БНД, НД, БХД-т хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтийг газар дээр нь тулган баталгаажуулах боломжгүй байсан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дүүргүүдийн ИТХ-аар дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос болон 2020 онд шинээр хэрэгжих нийт 85,553.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 357 ТАХ баталжээ.


Эдгээр 357 ТАХ-ээс 37,427.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 239 ТАХ нь 2020 онд шинээр хэрэгжих, 48,126.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 118 ТАХ нь өмнөх оноос дамжин хэрэгжсэн байна.

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 239 ТАХ-ээс 2020 онд 210 ТАХ-нд ХАА-г зохион байгуулсан байна. Харин зураг төсөв, ажлын даалгаваргүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, тендер зохион байгуулах ажил явагдаж байгаа зэргээс шалтгаалан 29 ТАХ-ний ХАА тухайн онд хэрэгжээгүй байна.

Өмнөх оноос дамжин хийгдсэн болон 2020 онд шинээр эхэлсэн 8 дүүргийн 39,056.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 226 ТАХ-нд дүүргүүдийн ЗДТГ болон “НХОГ” ОНӨААТҮГ, НАЗХГ, мөн “Алтан дуулга”, “Алтай Рөүд” ХХК зэрэг газрууд гэрээний үндсэн дээр хяналт хэрэгжүүлжээ.

2020 онд 32,405.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 182 ТАХ хэрэгжиж дууссан, 983.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 14 ТАХ хэрэгжилт дутуу 2021 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа бол 926.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 30 ТАХ хэрэгжээгүй байна.

2020 онд хэрэгжсэн ТАХ-г өмнөх онтой харьцуулахад ТАХ-ний тоо 7-оор буурсан ч төсөвт өртөг нь 16,261.0 сая төгрөгөөр өссөн байна. График



Тухайлбал: ЧД, СБД-т ТАХ-ний тоог 11-50 хүртэл, төсөвт өртгийн дүнг 3,030.5-3,453.2 сая төгрөгөөр багасгаж баталсан бол БГД, ХУД-т ТАХ-ний тоо нь 21-42 хүртэл багассан ч төсөвт өртгийн дүн нь өмнөх оноос 3,975.2-16,741.5 сая төгрөгөөр өсжээ.

Хүснэгт 1. 2019, 2020 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ

/сая.төг/

№	Дүүргийн нэр	2019 он		2020 он		Өсөлт, бууралт	
		Баталсан ТАХ тоо	Төсөвт өртөг	Баталсан ТАХ тоо	Төсөвт өртөг	ТАХ тоо	Төсөвт өртөг
1	БНД	4	126.0	21	441.0	17	315.0
2	БГД	56	4,678.9	35	8,654.1	-21	3,975.2
3	БЗД	31	4,034.2	45	5,313.3	14	1,279.1
4	БХД	-	-	3	33.1	3	33.1
5	НД	11	280.6	12	530.3	1	249.7
6	СХД	31	4,464.5	29	4,623.8	-2	159.3
7	СБД	166	38,924.0	116	35,893.5	-50	(3,030.5)
8	ЧД	33	11,477.8	22	8,024.6	-11	(3,453.2)
9	ХУД	32	5,298.7	74	22,040.2	42	16,741.5
	Нийт	364	69,284.7	357	85,553.9	-7	16,269.2

Аудитын түүврийг хийхдээ МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/351 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс 2020 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг болон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- 2020 онд худалдан авалт зохион байгуулсан 31,326.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 192 ТАХ-ээс 24,443.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 151 ТАХ буюу 78.6%-ийг ХАА-ны түүвэрт;
- 2020 онд санхүүжилт олгосон 27,247.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 91 ТАХ-ээс 22,500.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 56 ТАХ буюу 61.5% гүйцэтгэлийн түүвэрт хамруулсан.

БҮЛЭГ 1. ХУУЛИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТАХ-Г ТӨЛӨВЛӨЖ БАТЛУУЛСАН ЭСЭХ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.4¹ дэх заалтын дагуу нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Дүүргийн ИТХ-аас дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжих 37,427.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 239 ТАХ, өмнөх оноос он дамжин хэрэгжих 48,126.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 118 ТАХ, нийт 85,553.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 354 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталж, төсвийн тодотголоор дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- 3,551.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 29 ТАХ шинээр нэмэгдэж;
- 3,474.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 26 ТАХ хасагджээ.

Хүснэгт 2. Дүүргүүдийн ИТХ-аар баталсан ТАХ

№	Дүүргийн нэр	Анх батлагдсан		Нэмэлтээр		Хасагдсан		Сүүлийн тодотголоор	
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	БЗД	55	6 180.3	-	-	10	867.0	45	5 313.3
2	БГД	37	11 684.1	2	340.0	4	270.0	35	8 654.1
3	СХД	28	4 762.8	4	48.0	3	187.0	29	4 623.8
4	СБД	107	35 550.4	16	2 997.1	7	2 090.0	116	35 893.5
5	ХУД	73	18 597.0	1	40.0	-	-	74	22 040.2
6	ЧД	21	8 104.3	1	58.0	-	-	22	8 024.6
7	БНД	21	441.0	-	-	-	-	21	441.0
8	НД	9	522.3	5	68.0	2	60	12	530.3
9	БХД	3	33.1	-	-	-	-	3	33.1
Нийт		354	85 875.3	29	3 551.1	26	3 474.0	357	85 553.9

БГД, ХУД, НД, ЧД-үүд нь ТАХ-ны анхны батлагдсан үнийн дүнг тодотголоор оруулахдаа өөрчилснөөр 26 ТАХ-г хасаж, 29 ТАХ-г нэмснээс шалтгаалж төсөвт өртөг нь анх баталсан дүнгээс 398.5 сая төгрөгөөр хасагдсан байна. Дээрх байдлаар өөрчлөлт орж нийт 85,553.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 357 ТАХ-г баталжээ.

1.1. Хөрөнгө оруулалтын ТАХ-г Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөж батлуулсан уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 357 ТАХ-г 9 дүүргүүдийн 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан эсэхийг тулган баталгаажууллаа.

- 42,395.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 150 ТАХ буюу 42.0% нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд;
- 38,612.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 147 ТАХ буюу 41.2% Засаг даргын мөрийн хөтөлбөрт тус тус тусгагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3², 63.4³, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна. Хавсралт 1.

¹ 8.5.4. “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батлах.”

² 63.3. “Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.”

³ 63.4. “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална.”

**Хүснэгт 3. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл,
Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаагүй ТАХ**

№	Дүүргийн нэр	Нийт ТАХ-ний тоо	ЭЗНХҮЧ-д тусгаагдаагүй		ЗДМХ-т тусгаагдаагүй	
			ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	БЗД	45	30	3 560.2	32	3 652.2
2	БГД	35	16	4 232.7	15	3 892.9
3	СХД	29	15	1 868.6	16	1 938.6
4	СБД	116	42	23 227.0	9	16 476.4
5	ХУД	74	13	1 206.4	35	7 449.3
6	ЧД	22	12	1 669.6	12	4 370.5
7	БНД	21	13	323.5	18	390.0
8	НД	12	8	442.2	8	442.2
9	БХД	3	1	4.0	2	24.0
Нийт дүн		357	150	36 530.2	147	38 636.1

Дүгнэлт: 2020 оны хэрэгжүүлэхээр жагсаалтад батлагдсан ТАХ-ний 41.6% нь дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөртэй бүрэн уялдаагүй байна.

1.2. Зураг төсөв, ТЭЗҮ, газрын зөвшөөрөлтэй ТАХ баталсан уу?

2020 онд хэрэгжүүлэхээр баталсан 239 ТАХ-ээс 73 нь зураг төсөв шаардлагатай ТАХ байна. Үүнээс 1,450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ буюу 8.2%-ийг зураг төсөвгүй баталсан байна. Хавсралт 2. Үүнд:

- ЧД-т хэрэгжих 16 дугаар хороо, Ахмадын төв орчмын тохижилт хийх ажил, төсөвт өртөг 150.0 сая төгрөг;
- ЧД-т хэрэгжих 13-р хороо, Сургуулийн 33 дугаар гудамжнаас, 15 дугаар хороо Жаргалантын 47 дугаар гудамж хүртэлх авто зам /500м/ ажил, төсөвт өртөг 600.0 сая төгрөг;
- БГД-т хэрэгжих Баянгол дүүргийн архивын барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил, төсөвт өртөг 400.0 сая төгрөг;
- БГД-т хэрэгжих Тохижилт бүтээн байгуулалтын зураг төслийн ажил, төсөвт өртөг 220.0 сая төгрөг;
- ХУД-т хэрэгжих Гүний худаг байгуулах /14 дүгээр хороо/ ажил, төсөвт өртөг 30.0 сая төгрөг;
- БНД-т хэрэгжих Дүүргийн авто замын засвар шинэчлэлтийн зураг төсөв боловсруулах ажил, төсөвт өртөг 50.0 сая төгрөг.

Зураг төсөвгүй ТАХ баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴, 29.5⁵ дах заалтыг зөрчжээ.

Хүснэгт 4. Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ

№	Дүүрэг нэр	Зураг төсөв батлах шаардлагатай нийт ажил	Зураг төсөв хугацаандаа батлуулаагүй болон зураггүй	
			ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	БЗД	11		
2	БГД	2	2	620.0
3	СХД	7		
4	СБД	47		
5	ХУД	24	1	30.0
6	ЧД	10	2	750.0
7	БНД	1	1	50.0
8	НД			
9	БХД	1		
Нийт		120	6	1 450.0

⁴ 29.4. "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана."

⁵ 29.5. "Энэ хуулийн 28.3-т заасан шаардлагыг нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нэгэн адил мөрдөнө."

ТАХ-г төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, урьдаас төлөвлөгдсөн хэрэгжихэд бэлэн, нэн шаардлагатай ТАХ-г тусгаагүй зэргээс шалтгаалан тогтоолоор баталсан дэд бүтэц, тохижилт зэрэг бүтээн байгуулалтын ажлууд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй болох, он дамжих, төсөвт өртөг нь нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэж байна.

Дүгнэлт: 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зураг төсөв шаардлагатай 120 ТАХ-ний 95.0% нь зураг төсөвтэй байна.

БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭСЭХ

Дүүргүүд Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.6⁶-д заасны дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг батлуулсан байна.

2020 онд худалдан авахаар төлөвлөсөн нийт 34,277.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 210 ТАХ-ээс 199 ТАХ-нд ХАА зохион байгуулж, үүнээс 31,326.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 192 ТАХ-ний гүйцэтгэчийг сонгон шалгаруулжээ.

Хүснэгт 5. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ

№	Дүүргийн нэр	2020 онд хэрэгжих		Гүйцэтгэгч сонгон шалгарсан			Гүйцэтгэгч шалгараагүй		/сая.төг/ Сонгон шалгаруулалт явагдаагүй	
		Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Шалгарсан өртөг	Тендерийн хэмнэлт	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	БНД	8	336.0	6	250.2	4.8			2	81.1
2	БХД	3	33.1	3	33.0	0.1				
3	БГД	16	7 917.5	14	7 042.2	255.3			2	620.0
4	БЗД	30	2 816.4	29	2 761.7	52.7			1	2.0
5	НД	10	517.3	10	475.9	41.4				
6	СХД	10	1 036.6	8	893.3	28.7	1	14.6	1	100.0
7	СБД	72	6 218.7	67	5 769.7	355	3	74.4	2	19.7
8	ХУД	41	13 645.5	37	13 031.4	285.9	2	98.0	2	230.0
9	ЧД	20	1 756.1	18	1 069.3	80.7	1	600.0	1	6.1
	Дүн	210	34 277.2	192	31 326.7	1 104.6	7	787.0	11	1 058.9

ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан 1,845.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил дараах шалтгаанаар хэрэгжээгүй байна. Үүнд:

- Харин 787.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ буюу 3.3%-д сонгон шалгаруулалт явагдсан гүйцэтгэгч шалгараагүй;
- 1,058.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 ТАХ нь буюу 5.2% нь газрын асуудал шийдэгдээгүй болон зураг төсөвгүй мөн тодотголоор хасагдсан зэрэг шалтгаанаар сонгон шалгаруулалт явагдаагүй.

2.1. Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан уу?

Дүүргийн ЗД нарын 108 удаагийн захирамжаар ХАА-г зохион байгуулан гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороодыг байгуулжээ.

ХАА зохион байгуулсан ТАХ-ний худалдан авалтын 46.4%-ийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 3.1%-ийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар, 47.9%-ийг харьцуулалтын аргаар, 2.6%-ийг шууд гэрээ байгуулах аргаар тус тус зохион байгуулжээ.

⁶ 31.1.6.худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.

Хүснэгт 6. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам

№	Дүүргийн нэр	Гүйцэтгэгч сонгон шалгарсан		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын аргаар		Шууд гэрээ байгуулах		Зөвлөх үйлчилгээ	
		Тоо	Шалгарсан өртөг	Тоо	Шалгарсан өртөг	Тоо	Шалгарсан өртөг	Тоо	Шалгарсан өртөг	Тоо	Шалгарсан өртөг
1	БЗД	29	2 761.8	13	1 874.8	13	501.2	1	5.8	2	380.0
2	БГД	14	7 042.2	7	6 679.2	7	363.0	-	-	0	-
3	СХД	8	893.3	4	717.8	4	175.5	0	-	0	-
4	СБД	67	5 769.7	30	4 051.1	36	1 360.1	0	-	1	358.6
5	ХУД	37	13 031.4	16	12 016.7	19	725.0	1	89.8	1	200.0
6	ЧД	18	1 069.3	13	859.5	3	93.8	1	79.0	1	36.9
7	БНД	5	250.2	2	78.4	3	121.8	-	-	1	50
8	НД	10	475.9	4	339.3	6	136.7	-	-	0	-
9	БХД	3	33	0	-	1	20.0	2	13.0	0	-
Нийт дүн		192	31 326.7	89	26 616.8	92	3 497.1	5	187.6	6	1 025.5


СБД, ЧД-ийн ЗДТГ-аас 25.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 ТАХ-г босго үнээс хэтрээгүй тул шууд худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт 7. Шууд худалдан авах гэрээ байгуулсан ТАХ

№	Дүүргийн нэр	Тоо	Гэрээний дүн
1	СБД	2	6.1
2	ЧД	1	19.4
Нийт		3	25.5

Аудитаар 2020 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 31,326.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 192 ТАХ-с 24,443.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 151 ТАХ буюу 78.6%-ийг түүвэрт хамруулсан.

График 2. Хэрэгжсэн ТАХ-ээс түүвэрт хамрагдсан тоо



БЗД, БГД, ХУД, ЧД, СБД, СХД, БНД-ийн ХААА нь үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой заавар журмуудыг мөрдөөгүй, ТББ-д тусгасан санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, тусгай зөвшөөрөл, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12.3⁷ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. Хавсралт 3. Тухайлбал:

⁷ 12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

БЗД-ийн ХААА-аас зохион байгуулсан ТАХ:

- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.4⁸ дэх хэсэгт заасан үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах иргэдийн төлөөллийн томилсон шийдвэрийг гаргасан эсэх нь тодорхойгүй, баримт материалд хавсаргаагүй;
- “Баянзүрх дүүрэгт суудлын авто машин худалдан авах” Төсөвт өртөг 60.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Дата хаус центр” ХХК. Нийлүүлэх 2 ширхэг автомашины гаалийн бичигт тусгагдсанаар тухайн автомашинууд нь гэмтэлтэй /урд гупер, копуд, крыло/ байхад үнэлгээний хороо харгалзаж үзээгүй, тус компанийг гүйцэтгэгчээр шалгаруулсан.
- БЗД-ийн авто баазын камержуулалтын ажил. Төсөвт өртөг 22.3 сая төгрөг. Гүйцэтгэгч “Эрчу” ХХК. Гэрээг гүйцэтгэх удирдах болон инженер техникийн ажилтнуудын тухайн байгууллагад ажилладаг эсэхийг тодорхойлох нийгмийн даатгал төлсөн баримт, лавлагаа ирүүлээгүй байхад үнэлгээнд харгалзаагүй. Үнэлгээний хорооны гишүүд нь ашиг сонирхлын зөрчил илэрхийлэх хуудас бөглөөгүй.

БГД-ийн ХААА-аас зохион байгуулсан ТАХ:

- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 29.1⁹-т заасан захиалагч буюу ЗДТГ-аас гэрээ байгуулахаар эрх олгохоор шийдвэрлэж энэ тухай гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ гэсэн заалтыг зөрчин Худалдан авах ажиллагааны албанаас тендерт шалгарсан байгууллагад мэдэгдэл хүргүүлсэн.

БНД-ийн ХААА-аас зохион байгуулсан ТАХ:

- Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд автомашин худалдан авах. Төсөвт өртөг 80.0 сая төгрөг. 1-р багц ажил. Гүйцэтгэгч “Уаз мега” ХХК. Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэгт гишүүн А.Эрхэсийн гарын үсэг зурагдаагүй. ТБОНӨХБӨҮХАТ хуулийн 21.1¹⁰ дэх хэсэгт заасан тендерийн урилгыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй. 2-р багц ажил. “Роял Алтай констракшн” ХХК. Ижил төстэй ажлын гэрээ акт ирүүлэхээр ТШӨХ-д тусгасан ч ирүүлээгүй. Үнэлгээний хороо нь ТШӨХ-д тусгагдсан бүрдлийг гүйцэтгэгчээр шалгарсан “Роял Алтай” ХХК дутуу ирүүлсэн байхад үнэлгээний хүснэгтийг бүх гишүүд бүрэн ирүүлсэн гэж бөглөсөн.
- “ОБХ-ийн цахилгаан эрчим хүчний чанарыг сайжруулахад шаардагдах материал худалдан авах” Төсөвт өртөг 40.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Чандмань буудай” ХХК. Архивын баримтад тус байгууллага нь тайлант үед -166.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байхад тендерт шалгаруулсан.

СБД-ийн ХААА-аас зохион байгуулсан ТАХ:

- “Дүүргийн 20 дугаар хороонд тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж, дайрган хучилт хийх” Төсөвт өртөг 320.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “БСМ” ХХК. ТБОНӨХБӨҮХАТ хуулийн 21.1¹⁰ дэх хэсэгт заасан тендерийн урилгыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй. Үнэлгээний хорооны гишүүн Г.Амгалан, Г.Энхтөр, Ю.Болорцэцэг, Э.Цэнд-Аюуш нар ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийн “сонирхлын зөрчилтэй эсэх”-ийг бөглөөгүй.

⁸ 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

⁹ 29.1.Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

¹⁰ 21.1.Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

- “Дүүргийн 4 дүгээр хороонд авто замын засвар, шинэчлэлт, нөхөөс болон бусад замын байгууламж хийх” Төсөвт өртөг 275.8 сая төгрөг. Гүйцэтгэгч “Жи Пи Экспресс Финанс” ХХК. Тендерийн урилгыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй. Үнэлгээний хорооны гишүүн З.Азаяа, С.Должин нарын сертификатын хугацаа нь тендерийн үйл ажиллагааны явцад буюу 2020.04.28, 2020.03.27-ны өдөр дуусгавар болсон. ТБОНӨХБӨҮХАТ хуулийн 29.1¹¹ дэх хэсэгт заасан тендерт оролцсон “Өвгөдийн жим” ХХК-д шалгараагүй тухай мэдэгдэл хүргүүлсэн баримт байхгүй байна.

СХД-ийн ХААА-аас зохион байгуулсан ТАХ:

- Үнэлгээний хорооны гишүүд нь ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны гишүүдээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг бөглөөгүй нь Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын Хавсралт 1¹²-г зөрчсөн.
- Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулаагүй нь Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3.2¹³ заалтыг зөрчсөн.

ХУД-ийн ХААА-аас зохион байгуулсан ТАХ:

- Үнэлгээний хорооны гишүүний ХАА-ны чиглэлээр мэргэшсэн байх сертификатын хугацаа дууссан байхад гишүүнээр ажиллуулсан нь Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 2.2¹⁴ дэх заалтыг зөрчсөн.
- “Явган хүний зам барих” Төсөвт өртөг. 463.3 сая төгрөг. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгийг илэрхийлэх хуудсанд үнэлгээний хорооны гишүүн сонирхлын зөрчилтэй эсэх бөглөгдөөгүй.

ЧД-ийн ХААА-аас зохион байгуулсан ТАХ:

- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах иргэдийн төлөөллийн томилсон шийдвэр нь үнэлгээний хороо байгуулагдсан огнооноос хойш гарсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.4¹⁵ дэх хэсэгт заасныг зөрчсөн.
- Үнэлгээний хорооны гишүүд нь үнэлгээний хуудсыг үнэлж үнэлгээ дутуу хийсэн нь Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 4.3¹⁶ дахь заалтыг зөрчсөн.

Иймд илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Цаашид зөрчил давтагдан гарсан тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахыг анхаарах шаардлагатай байна.

Цаашид худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа, ТБОНӨХБАҮХАТ хууль, Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл

¹¹ 29.1.Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

¹² Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын Хавсралт 1 Үнэлгээний хорооны гишүүдээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг

¹³ 3.2 Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана.

¹⁴ 2.2 Хуулийн 47.6-д заасны дагуу Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

47.6 Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

¹⁵ 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

¹⁶ Тендер шалгаруулалтыг нээсэн өдөр үнэлгээний хороо эхний хуралдааныг хийх бөгөөд хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээг хийнэ. 28.2 Тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтааж аль болох богино хугацаанд хийнэ.

ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: 2020 онд худалдан авахаар төлөвлөсөн нийт ТАХ-ний 91.0%-ийн ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулжээ. Аудитын түүвэрт хамрагдсан 24,443.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 151 ТАХ-ээс 11,710.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 ТАХ буюу 35.1% нь холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан уу?

Аудитын түүвэрт хамрагдсан 151 ТАХ-ний тендерийн баримт бичиг, гүйцэтгэгчээс ирүүлсэн баримт, материалыг шалгуур үзүүлэлттэй тулган шалгахад 2,916.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 ТАХ-нд шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан нь ТБОНӨХБӨҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” заалтыг зөрчжээ. Хавсралт 4.

Хүснэгт 8. Тендерийн баримт бичигт заасан нөхцөл хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан

№	ХАА зохион байгуулсан	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Шалгуур хангаагүй үзүүлэлтийн тоо
1	БЗД-ийн ХААА	10	820.8	21
2	БГД-ийн ХААА	1	60.0	1
3	СХД-ийн ХААА	2	142.0	9
4	ХУД-ийн ХААА	8	1 398.9	22
5	БНД-ийн ХААА	5	255.0	9
6	ЧД-ийн ХАА	1	200.0	2
	Нийт дүн	27	2 916.7	64

Дээрх 27 гүйцэтгэгчийн ирүүлсэн баримтыг шалгахад ерөнхий нөхцөлийг магадлах шалгуур 30, техникийн чадавх болон туршлагыг үнэлэх шалгуур 25, бусад 9, нийт 64 шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна. Тухайлбал:

БЗД-ийн ХААА-с зохион байгуулсан ТАХ:

- Гэр хороолол болон орон сууцны хорооллын гудамж талбайн хаягжуулалтын ажил. Төсөвт өртөг 100.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Мөнх аригу трейд” ХХК. Санхүүгийн аудитын 2018 оны тайланг аудитаар баталгаажуулсан дүгнэлт ирүүлээгүй. Инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, иргэний үнэмлэх, CV анкет, мэргэжлийн үнэмлэхийн хуулбар ирүүлээгүй /нотлох баримт хангалтгүй/;
- “Баянзүрх дүүрэгт суудлын авто машин худалдан авах”. Төсөвт өртөг 60.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Датахаус” ХХК. Сүүлийн 2 жилийн хугацааны туршлагад автомашин нийлүүлсэн туршлагын баримт материал дутуу фото зураг байхгүй. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь 2018 онд 57,782.1, 2019 онд 30,657.3 төгрөгийн хөрвөх хөрөнгийн чадвартай байгаа нь шаардлагад нийцээгүй байна.

СХД-ийн ХААА-с зохион байгуулсан ТАХ:

- “Дулааны шугам өргөтгөх”. Төсөвт өртөг 92.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Баялаг говь” ХХК. Инженер Г.Мөнхбат, О.Ариунжаргал нь ТББ-т заасан мэргэжлийн шаардлага хангаагүй;
- “Зарлан мэдээллийн дуут дохионы цамхаг суурилуулах” Төсөвт өртөг 50.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Буянт мянгад” ХХК. ТШӨХ-д заасан тусгай зөвшөөрөлгүй. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тодорхойлолт, зайлшгүй шаардлагатай ажилчдын нийгмийн даатгалын лавлагааг ирүүлээгүй 2018, 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын талаар захиалагчаас чанартай гүйцэтгэсэн эсэх тодорхойлолт ирүүлээгүй. Дээрх оны

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

санхүүгийн тайлан болон 2019 оны жилийн эцэст хийсэн аудитын дүгнэлтийг ирүүлээгүй.

ЧД-ийн ХААА-с зохион байгуулсан ТАХ:

- “Дүүргийн спорт цогцолборт шаардлагатай хөгжим апартур нийлүүлэх”. Төсөвт өртөг 200 сая төгрөг. Гүйцэтгэгч “Цуурай” ХХК. Сүүлийн 2 жилийн борлуулалтын хэмжээ, сүүлийн 2 жилийн түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээг ирүүлээгүй.

ХУД-ийн ХААА-с зохион байгуулсан ТАХ:

- “Үерийн ус зайлуулах сувгийн засвар”. Төсөвт өртөг 41.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Жей Эм Жи ЮУ” ХХК. ТББ-т заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан П.Мягмаржаргалын ажилласан жилийн хугацаа туршлагын шаардлага хангахгүй. Тендерт оролцогч байгууллага баталгааны бичиг ирүүлээгүй;
- “Явган хүний зам барих ажил”. Төсөвт өртөг 463.6 сая төгрөг. Гүйцэтгэгч “Морин сувд” ХХК. Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй, зураг төслийн ажилчдын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримт байхгүй;
- “Дүүргийн харьяа байгууллага, хороодын засвар”. Төсөвт өртөг 160.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Центр лайн констракшн” ХХК. ТББ-т заасан тусгай зөвшөөрлийг нотариатаар баталгаажуулан ирүүлээгүй. Тусгай зөвшөөрөлд ажил гүйцэтгэхэд шаардлагатай БА-6.2 заалт байхгүй, инженер техникийн ажилчдын нийгмийн даатгал төлсөн талаарх баримтыг ирүүлээгүй, зайлшгүй шаардлагатай машин механизмгүй байсан.

БНД-ийн ХААА-с зохион байгуулсан ТАХ:

- “Дулааны станц ТӨХК-д шуурхай ажиллагааны авто машин худалдан авах”. Төсөвт өртөг 35.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “УАЗ МЕГА” ХХК. Шүүхийн төрөлжсөн архив, татвар, НД, ШШГЕГ зэрэг газрын тодорхойлолтууд нь тендерийн урилга нийтлэгдэхээс өмнөх он сартай. Байгууллагын харилцах банкны дансны үлдэгдэл, зээл авах боломжтойг нотолсон тодорхойлолт ирүүлээгүй;
- “Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд автомашин худалдан авах”. Төсөвт өртөг 80.0 сая төгрөг /Шүүх, Улсын бүртгэл, ЗДТГ, Багануур-Ус ААТҮГазарт/ ажил. Гүйцэтгэгч “Роял Алтай констракшн” ХХК. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээ болон акт ирүүлээгүй. Өөр газар хандсан шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа ирүүлсэн. /Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т хандсан Орхон аймаг дахь шүүхийн тамгын газрын лавлагаа/.

2020 оны дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБӨҮХАТ хууль болон тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт хангаагүй гүйцэтгэгчийн тоо, төсөвт өртгийг 2018, 2019, 2020 оноор нь харьцуулж үзлээ.

Хүснэгт 9. 2018-2020 онд шалгуур хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан ТАХ-ний тоо

Он	Түүвэрт хамрагдсан ТАХ-ний тоо	ТББ ч заасан шалгуур хангаагүй үзүүлэлт			/сая.төг/
		Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Хувь	
2018	280	21 828.2	43	15%	
2019	181	1 542.1	17	9.4%	
2020	151	2 916.7	27	17.9%	
Нийт		26 287.0			

Хүснэгтээс харахад 2018, 2019 оны дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитаар худалдан авах

ажиллагаатай холбоотой тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан зөрчил дахин давтагдсаар байна.

Зөрчил давтагдсаар байгаа нь үнэлгээний хорооны гишүүдийн мэдлэг, ур чадвар нь дутмаг, ажилдаа хайнга хариуцлагагүй хандсан зэрэгтэй холбоотой байна. Холбогдох шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгарснаар ажил төлөвлөсөн хугацаандаа дуусахгүй байх, чанаргүй болох зэрэг үр дагавартай байна.

Иймд илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Цаашид зөрчил давтагдан гарсан тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахыг анхаарах шаардлагатай байна.

Дүгнэлт: Аудитын түүвэрт хамрагдсан 24,443.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 151 ТАХ-ээс 2,916.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 ТАХ буюу 17.9%-д ТББ болон ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

БҮЛЭГ 3. ТАХ-НИЙ САНХҮҮЖИЛТ БОЛОН ХЭРЭГЖИЛТ НЬ ҮР НӨЛӨӨТЭЙ, ҮР ДҮНТЭЙ БАЙСАН ЭСЭХ

Нийслэлийн 9 дүүрэгт 2020 онд шинээр 24,646.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 220 ТАХ, өмнөх оноос дамжин хэрэгжсэн 29,490.6 сая төгрөгийн дүнтэй 109 ТАХ, нийт 54,136.7 сая төгрөг дүнтэй 329 ТАХ хэрэгжиж байна.

Үүнээс 2020 онд 43,881.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 275 ТАХ буюу 81.1% нь бүрэн хэрэгжсэн, 4,437.0 сая төгрөгийн дүнтэй 22 ТАХ буюу 8.2%-ийн хэрэгжилт дутуу, 1,077.5 сая төгрөгийн дүнтэй 32 ТАХ буюу 10.7% нь хэрэгжээгүй байна.

Хүснэгт 10. ТАХ-ний хэрэгжилтийн судалгаа

№	Дүүргийн нэр	Он	Хэрэгжсэн TAX		Хэрэгжилт дутуу TAX		Хэрэгжээгүй TAX		/сая.төг/ Нийт TAX	
			Тоо	Гэрээний дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Гэрээний дүн
1	БГД	2019	14	2 145.4	-	-	1	416.8	15	2 562.2
		2020	13	6 213.8	1	400.0	1	220.0	15	6 833.8
2	БЗД	2019	17	2 959.7	1	50.7	2	-	20	3 010.4
		2020	21	1 882.4	4	172.8	1	49.5	26	2 104.7
3	СХД	2019	15	305.5	-	-	-	-	15	305.5
		2020	8	447.3	2	297.6	1	240.5	11	985.4
4	ЧД	2019	7	5 514.5	-	-	-	-	7	5 514.5
		2020	14	6 156.1	4	62.8	3	-	21	6 218.9
5	ХУД	2019	11	3 259.5	-	-	3	4 741.0	14	8 000.5
		2020	30	2 600.8	-	-	16	-	46	2 600.8
6	НД	2020	11	513.9	-	-	1	-	12	513.9
7	БНД	2020	18	373.1	2	-	1	-	21	373.1
8	БХД	2020	3	33.0	-	-	-	-	3	33.0
9	СБД	2019	34	6 735.7	5	3 205.5	1	68.8	40	10 010.0
		2020	59	4 740.5	3	247.6	1	81.9	63	5 070.0
	Нийт		275	43 881.2	22	4 437.0	32	5 818.5	329	54 136.7

3.1. Захиалагчийн хяналтыг эрх бүхий этгээд хяналт тавьж байна уу?

Захиалагчийн хяналтыг “НХОГ” ОНӨААТҮГ, БЗД, ХУД-ийн ЗДТГ-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, БГД-д “Алтан дуулга” ХХК, СХД-д дүүргийн захиалагчийн алба ОНӨААТҮГ, ЧД-т “Алтай Рөүд” ХХК зэрэг байгууллагууд хэрэгжүүлжээ.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн дээрх этгээдүүд эрх бүхий эсэхийг дүрэм, чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, холбогдох баримт бичиг зэрэгтэй тулган шалгасан. Үүнд:

- БЗД, ХУД-ийн холбогдох хэлтсээс нийт 28 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн бөгөөд 2 албан хаагч хяналт хэрэгжүүлэн ажиллажээ. Эдгээр албан хаагч санхүү, эрх

- зүй, эдийн засаг, экологийн чиглэлийн мэргэжилтэй, мэргэжлийн бус, холбогдох албан тушаалд 1-4 жил ажилласан.
- “НХОГ” ОНӨААТҮГ, СХД-ийн захиалагчийн алба ОНӨААТҮГ, “Алтан дуулга” ХХК, “Алтай Рөүд” ХХК зэрэг нь 3Г-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2¹⁷-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдүүд байна.

Дүгнэлт: Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний захиалагчийн хяналтыг мэргэжлийн бус ажилтнууд, ажил мэргэжилдээ хариуцлаггүй инженерүүд хэрэгжүүлснээр төсвийн мөнгийг үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй зарцуулж чадаагүй байна.

3.2. Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

БЗД, БГД, СХД, ХУД, ЧД-д хэрэгжиж дууссан 91 ТАХ-ээс 14,828.8 сая төгрөгийн дүнтэй 32 ТАХ-нд мэргэжлийн байгууллага болон гэрээт инженерүүд хяналт тавьсан бол 12,417.3 сая төгрөгийн дүнтэй 59 ТАХ-нд дүүргүүдийн ЗДТГ-ын холбогдох хэлтсээс тус тус захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

Аудитад 2020 онд хэрэгжиж дууссан 32,405.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 182 ТАХ-ээс төрөл тус бүрээс түүвэрлэн 22,500.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 56 ТАХ-г хамруулан газар дээр нь шалгаж тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчлүүд илэртэй. Үүнд:

Хүснэгт 11. Аудитын түүвэрт хамрагдсан ТАХ

№	Дүүргийн нэр	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ		Үүнээс аудитын түүвэрт хамрагдсан	
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн
1	БГД	20	8 287.1	9	6 602.1
2	ХУД	28	9 945.5	15	8 439.7
3	СХД	16	1 722.5	8	691.5
4	БЗД	15	2 472.8	13	2 267.9
5	ЧД	12	4 819.2	11	4 499.3
	Нийт	91	27 247.1	56	22 500.5

БЗД-ийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

Нийт 2,267.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 13 ТАХ-г түүвэрлэн үзэхэд 2 ТАХ-нд зөрчил илэрсэн. Үүнд:

- “Өөрөө буулгагч ачааны машин” авах ажил. Гэрээний дүн: 194.2 сая төгрөг. Гүйцэтгэгч “Энх Энгүүн зам” ХХК 2020.09 сард нийлүүлэгдсэн 2 ширхэг Howo маркийн ачааны автомашин. Хүлээж авсанаас хойш хөл хорио тогтоогоод ашиглаагүй, явах эд анги нь эвдэрсэн. Засварт байгаа. Ашиглалтын шаардлага хангахгүй байна.
- “Суудлын авто машин худалдан авах” Гэрээний дүн: 59.8 сая төгрөг. Гүйцэтгэгч “Дата хаус центр” ХХК, 2010 онд үйлдвэрлэгдсэн 2 ширхэг Prius-30 маркийн суудлын автомашин. Ижил төрлийн авто машинтай харьцуулахад 7.5 сая төгрөгийн илүү үнээр нийлүүлэгдсэн. Гаалийн бүрдүүлбэрийн баримт бичигт “Эвдрэлтэй автомашин” гэсэн ангилалд тусгасан. Ашиглалтын байдалтай танилцахад кузов нь эвдэрч хэмхэрсэн байдалтай байсан.

СХД-ийн захиалагчийн алба ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ.

¹⁷ 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

Нийт 691.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 ТАХ-г түүвэрлэн үзэхэд 3 ТАХ-нд зөрчил илэрсэн. Үүнд:

- “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Амралт цогцолборын газрын барилгын ажил”. Гэрээний дүн: 248.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Алтан шар говь” ХХК. Барилгын ажлын зураг төсөв нь магадлалаар батлагдаагүй байхад барилгын ажлыг эхлүүлсэн. Захиалагчаас ирүүлсэн зургийн даалгаварт барилгажих талбайн хэмжээг 315м² гэж тусгасан байхад ажлын тоо хэмжээг 27м²-аар багасгаж 288м² талбайн суурийг цутгаж өрлөг хийсэн. Өрлөг хийхдээ налуугийн нэг хэмийг алдагдуулж, чанаргүй гүйцэтгэсэн. Захиалагчаас гүйцэтгэсэн ажлын гэрээг дүгнэж 53.0%-н санхүүжилт буюу 133.1 сая төгрөгийг олгоходоо гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6¹⁸, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.3¹⁹ дэх заалтыг зөрчсөн байна.



- “Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил”. Гэрээний дүн: 75.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Затус ХХК. 2020.10 сард ашиглалтад хүлээн авсан. Ашиглалтад хүлээж авах комиссын хурал тэмдэглэл болон ажил хүлээлцсэн актад ажлын тоо хэмжээг дурдаагүй. Бүх ажлыг бүрэн хийгдсэн гэж дүгнэсэн. Ажлын гүйцэтгэлтэй танилцахад төмөр торон хашааны будаг арилж, зэвэрсэн, доод хаяавчийг нь дутуу хийсэн, хөл бөмбөгийн талбайн зүлэгжүүлэлтийг чанаргүй материалаар хийснээс ховхорч, наалт нь салсан, сагсан бөмбөгийн талбайн суурь цемент эвдэрч, будаг нь ховхорсон, сандал нь зурагт тусгагдсаны дагуу 2 метр байхаар байхад 1.5 метрийн урттай сандал байршуулсан, ашиглалтын явцад эвдэрсэн. Иймд захиалагч болон гүйцэтгэгчид зөрчлийг 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор арилгаж, эргэн мэдэгдэх хугацаатай үүрэг даалгавар өгсөн.



¹⁸ 24.6. Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.

¹⁹ 4.3. Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна.

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

- “Авто замын зорчих хэсгийг өргөтгөх /13-р хороо, 9-р байрны хойд тал/” ажил. Гэрээний дүн: 39.6 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Шинэ цагийн зам” ХХК. Замын хашлага броджур эмтэрч хагарсан.


ХУД-ийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, эдийн засаг төлөвлөлтийн хэлтсээс хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

Нийт 8,439.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 15 ТАХ-г түүвэрлэн үзэхэд 5 ТАХ-нд зөрчил илэрсэн. Үүнд:

- “Нисэх яармагт дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажил. Гэрээний дүн: 678.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Чингисийн отог ХХК, ОАКС экспресс ХХК. Ажлын зурагт тэргэнцэртэй иргэдийн налуу шатыг тусгаагүй орхигдуулснаас гүйцэтгэлийн явцад хийлгэсэн ч тэргэнцэртэй иргэн явахад хүндрэлтэй эгц уруу байдалтай хийсэн, зорчих хэсгийг нь барьцалдуулагч материалаар будаагүйгээс гэмтэх бэртэх эрсдэлтэй, талбайн хэсгүүдийн явган хүний замд хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглүүлэх, анхааруулах хавтанг дутуу хийсэн байна. Чанаргүй материалаар хийснээс сагсан бөмбөгийн талбайн суурь цемент эвдэрч, будаг нь ховхорсон байна. ТАХ-г хараа хяналтгүй орхисноос гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ нь дутсан /4 ширхэг сандал, 1 ширхэг дасгалыг төхөөрөмж, гэрэлтүүлэг, хогийн сав эвдэрч ашиглах боломжгүй болсон.



- “Ахмадын хөгжлийн төвийн байр, тоног төхөөрөмж худалдан авах” ажил. Гэрээний дүн: 195.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жеопро Монголиа ХХК. 49 ширхэг чийрэгжүүлэлт, тавилга тоног төхөөрөмж үнэ нь зах зээлийн үнээс 2-3 дахин их үнэлгээтэйгээр нийлүүлэгдсэн байхад захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ харьцуулсан бодит үнийн тооцоолол хийгээгүй.



- “Замын индүү худалдан авах” ажил. Гэрээний дүн:88.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жеопро Монголиа ХХК. 2020 оны 6 дугаар сард нийлүүлэгдсэн. 2 сар ашигласан. Техникийн үзүүлэлт, арлын дугаар нь тодорхойгүй. Мотор хөлөрч, 4 дугуй нимгэрч язарсан байдалтай байсан. Аудитаар өгсөн үүрэг даалгаварын дагуу зөрчлийг арилгасан болно.
- “Ахмадын хөгжлийн төвийн орон сууц худалдан авах” ажил. Гэрээний дүн:142.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Моншике ХХК. Ажлын тоо хэмжээнд тусгагдсан чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй. Энэ талаар захиалагчаас тодруулахад байрны өртөг өндөр /142,500,000.0 төгрөг/ учраас нийлүүлээгүй гэж тайлбарласан. Тухайн 71.3м² байрных нь зах зээлийн үнэлгээг судалж үзэхэд ойролцоогоор 1м² нь 1,800,000.0 төгрөг буюу $71.3\text{м}^2 \times 1,800,000.0 = 128,340,000.0$ төгрөг болж байна. Тус байрыг 14,160,000.0 төгрөгийн илүү үнээр худалдан авсан байна.

Захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлсэн, ажилдаа хариуцлаггүй хандсанаас шалтгаалж, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн бараа, ажил үйлчилгээ нь чанаргүй, дутуу хийгдэх, зэх зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлэгдсэн байна.

Иймд илэрсэн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох дүүргүүд, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Цаашид зөрчил давтагдан гарсан тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахыг анхаарах шаардлагатай байна.

Дүгнэлт: Аудитын түүвэрт хамруулсан 22,500.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 56 ТАХ-ээс 1,729.9 сая гэрээний дүнтэй 9 ТАХ буюу 16.1%-д захиалагчийн хяналтыг хангалтгүй, үр дүн муутай хэрэгжүүлсэн нь төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжид сөргөөр нөлөөлж байна.

3.3. Захиалагчийн хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулсан уу?

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 43,881.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 275 ТАХ хэрэгжсэнээс захиалагчийн хяналт хийлгэх 40,398.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 168 ТАХ-ээс /6 дүүргийн хүрээнд/ 431 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал тооцож авсан байна.

Хүснэгт 12. Захиалагчийн хяналтын зардалд олгосон санхүүжилт

				/сая.төг/
№	Дүүргийн нэр	Хяналт хийсэн ажлын тоо	Хяналтын хэрэгжүүлсэн байгууллага	Шилжүүлсэн санхүүжилт
1	БГД	12	Алтан дуулга ХХК, НХОГ	13.9
		8	Алтан дуулга ХХК	51.9
2	СХД	16	Дүүргийн захиалагчийн алба ОНӨААТҮГ	28.6
3	ЧД	6	"Алтай Рөүд" ХХК, НХОГ	67.5
		6	"Алтай Рөүд" ХХК, НХОГ, НАЗХГ	3.3
4	ХУД	6	Дүүргийн төрийн сан	15.2
		22	Дүүргийн төрийн сан	30.5
5	БЗД	7	Дүүргийн төрийн сан	9.1
		8	Дүүргийн төрийн сан	0.1
6	СБД	46	Дүүргийн төрийн сан	69.6
		31	Дүүргийн төрийн сан	141.3
	Нийт	168	-	431

Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн “НХОГ” ОНӨААТҮГ, “Алтан дуулга” ХХК, “Алтай Рөүд” ХХК нь захиалагчийн хяналтын зардалд олгосон 165.2 сая төгрөгийг үйл ажиллагааныхаа зардалд зарцуулсан байна.

Харин БЗД, ХУД, СБД захиалагчийн хяналтын зардал 265.8 сая төгрөгийг төрийн сангийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлжээ.

Дүгнэлт: Захиалагчийн хяналтын зардлыг холбогдох газрууд үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

3.4 Санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэж олгосон уу?

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 2019 оноос он дамжин хэрэгжих болон 2020 онд шинээр хэрэгжих ТАХ-үүдэд олгохоор баталсан 59,265.7 сая төгрөгийн санхүүжилтээс гүйцэтгэгч байгууллагад 24,739.1 сая төгрөг буюу 41.7%-ийг олгожээ.

Нийт олгосон 59,265.7 сая төгрөгөөс 616.7 сая төгрөгийг дүүргүүд техник хяналтын зардал болон зураг төсөв, магадалшгүй ажил, зохиогчийн хяналтын зардалд зарцуулсан.

Хүснэгт 13. ТАХ-ний санхүүжилтийн судалгаа

№	Дүүрэг нэр	Өмнөх оноос хэрэгжсэн				2020 онд шинээр хэрэгжсэн				Нийт			
		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	15	984.2	14	888.8	15	4 127.5	13	3 485.6	30	5 111.7	27	4 374.4
2	БЗД	20	3 214.6	17	2 268.5	26	2 148.2	23	1 798.1	46	5 362.8	40	4 066.6
3	СХД	-	-	-	-	11	1 015.6	9	580.4	11	1 015.6	9	580.4
4	ХУД	14	3 435.4	8	3 259.5	30	2 297.5	30	1 920.0	44	5 732.9	38	5 179.5
5	ЧД	7	3 321.1	6	2 070.5	43	2 352.7	43	1 021.3	50	5 673.8	49	3 091.8
6	БНД	-	-	-	-	21	441	18	360.4	21	441	18	360.4
7	НД	-	-	-	-	12	522.4	11	513.9	12	522.4	11	513.9
8	БХД	-	-	-	-	3	33	3	33	3	33	3	33
9	СБД	36	30 048.7	31	3 639.8	63	5 323.8	61	2 899.3	99	35 372.5	92	6 539.1
	Нийт	92	41 004.0	76	12 127.1	224	18 261.7	211	12 612.0	316	59 265.7	287	24 739.1

Аудитын явцад 9 дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсээс санхүүжилт олгосон дансны хуулгыг гэрээний хэрэгжилттэй холбоотой баримтууд /гэрээ дүгнэсэн протокол, ажлын гүйцэтгэл, ажил хүлээлцсэн актууд/-тай тулган шалгахад олгосон нийт санхүүжилтийг бодит ажлын гүйцэтгэлд нь үндэслэн олгожээ. Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон дутуу ажилд үндэслэн олгосон зөрчил илрээгүй.

Хэрэгжиж дууссан ТАХ-ний барьцаанд 1,505.9 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, гэрээний үүргээ зөрчсөн 18 гүйцэтгэгчээс гэрээний хугацаа хэтрүүлсэн алдангид 56.6 сая төгрөг суутган тооцож дүүргийн төрийн сангийн дансанд байршуулжээ.

Хүснэгт 14. 2019, 2020 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги

№	Дүүргийн нэр	Батлагдсан төсөвт өртөг		Олгосон санхүүжилт дүн		Барьцаанд		Алдангид	
		ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн
1	БГД	15	2 576.6	12	888.8	12	79.8	2	1
		15	7 707.5	13	3 485.6	12	78.3	1	0.7
2	БЗД	20	3 214.6	17	2 268.5	15	115.1	-	-
		26	2 148.2	23	1 798.1	18	109.8	-	-
3	СХД	11	1 015.6	9	580.4	7	20.2	2	0.2
4	ХУД	14	10 586.2	8	3 259.5	-	-	-	-
		30	2 805.8	30	1 920.1	27	123.4	4	0.8
5	ЧД	7	5 908.2	7	3 922.9	6	200.9	1	35
		28	2 352.4	21	736	2	10.2	2	9.7
6	БНД	21	441	18	360.4	6	12.7	-	-
7	БХД	3	33.2	3	33.0	3	1.9	1	0.2
8	НД	12	522.4	11	513.9	11	25.7	4	8.4
9	СБД	36	30 048	31	3 639.8	32	470.27	1	0.6
		63	5 323.8	61	2 899.3	61	247.7	-	-
	Нийт	301	74 683.5	264	26 306.3	212	1 505.9	18	56.6

Дүүргүүдийн санхүүжилтийг тулган шалгах явцад СБД, ЧД-үүд 255.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ-нд 6.2 сая төгрөгийн /гэрээний үүргээ хугацаанд

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

биелүүлээгүй/ алданги тооцоогүй зөрчил илэрсэн тул алдангийг нөхөн тооцож авах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Хүснэгт 15. Гэрээний хугацаа хэтэрсэн ТАХ-ний хоногийн тооцоо

№	Дүүргийн нэр	ТАХ-ий нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэгч байгууллага	/сая.төг/ Хугацаа хэтэрсэн хоног Нөхөж тооцсон	
1	ЧД	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж	20	17.1	"Онцгой Өргөө" ХХК	38	1.7
		Дүүргийн спорт цогцолборт шаардлагатай тавилга тоног төхөөрөмж	200	105.0	"Компас саплай" ХХК	4	2.1
2	СБД	Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн автобус худалдан авах	140	133.3	"ДАРХАН НЭГДЭЛ" ХХК	18	2.4
		Нийт	360	255.4		60	6.2

Дүгнэлт: Санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд нь үндэслэн олгожээ.

3.5 Барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хүлээн авч, бүртгэлд тусгасан уу?

2019-2020 онд 32,405.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 275 ТАХ хэрэгжиж дууссан. Үүнээс аудитын түүвэрт хамрагдсан 6 дүүргийн хэмжээнд хэрэгжиж дууссан 155 ажлыг хүлээн авч, бүртгэлд тусгасан эсэхийг шалгахад хөрөнгийн бүртгэлд бүртгэж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1²⁰-дэх хэсэгт заасны дагуу тайлан баланст тусгажээ.

Хүснэгт 16. Хөрөнгийн бүртгэлийн судалгаа

№	Дүүргийн нэр	Бүртгэх		Бүртгэгдсэн		/сая.төг/ Бүртгэгдээгүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	22	2 712.6	22	2 712.6	-	-
2	СХД	27	976.1	27	976.1	-	-
3	ЧД	6	3 134.1	6	3 134.1	-	-
4	БЗД	25	3 168.0	25	3 168.0	-	-
5	ХУД	41	3 548.8	41	3 548.8	-	-
6	СБД	34	4 261.3	34	4 261.3	-	-
	Нийт	155	17 800.9	155	17 800.9		

Бүртгэсэн хөрөнгийг төрлөөр ангилбал дүүргийн өмчид 13,661.2 сая төгрөгийн өртөг бүхий 116, нийтийн эзэмшилд 3,452.3 сая төгрөгийн өртөг бүхий 30, ашиглагч байгууллагуудад 687.4 сая төгрөгийн өртөг бүхий 9 ТАХ бүртгэгдсэн байна.

Дүгнэлт: Ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгасан байна.

3.6. Төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зардлыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна уу?

Аудитын явцад илэрсэн зөрчлөөс харахад төсвийн зардлыг бууруулах, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх дараах боломж байна. Тухайлбал:

- "БЗД Замын цагдаагийн хэлтэст суудлын автомашин нийлүүлэх". Гэрээний дүн 42.9 сая төгрөг. Ижил үзүүлэлттэй суудлын автомашины зах зээлийн үнэлгээг судалж

²⁰ 9.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана."

- үзэхэд ойролцоогоор Hyundai Sonata-8 /Үйлдвэрлэсэн он: 2015 он.Хөдөлгүүр: Бензин/ маркын авто машин зах зээлийн үнэ 23.0 сая төгрөг байна. Тус машиныг 19.9 сая төгрөгийн илүү үнээр худалдан авсан;
- “БЗД суудлын автомашин худалдан авах” 2 ширхэг. Гэрээний дүн 59.7 сая төгрөг. /1 бүрийн үнэ 29.8 сая төгрөг/ Ижил үзүүлэлттэй суудлын автомашины зах зээлийн үнэлгээг судалж үзэхэд 1 бүрийн үнэ ойролцоогоор Toyota Prius-30 /Үйлдвэрлэсэн он: 2010 он/ 22.5 сая төгрөг байна. Тус 2 машиныг 14.7 сая төгрөгийн илүү үнээр худалдан авсан;
 - ХУД “Ахмадын хөгжлийн төвийн орон сууц худалдаж авч тохижуулах”. Гэрээний дүн 195.9 сая төгрөг. ТАХ-нд 60м^2 байрны зах зээлийн үнэлгээг судалж үзэхэд ойролцоогоор 1м^2 нь 2.2 сая төгрөг буюу $60\text{м}^2 \times 2.2$ сая төгрөг=132.0 сая төгрөг болж байна. Тус орон сууцыг тохижуулах ажлын хамт ойролцоогоор 45.0 сая төгрөгийн илүү үнээр худалдан авсан;
 - ХУД “Ахмадын хөгжлийн төвийн орон сууц худалдаж авч тохижуулах”. Гэрээний дүн 142.5 сая төгрөг. ТАХ-нд $71,3\text{м}^2$ байрны зах зээлийн үнэлгээг судалж үзэхэд ойролцоогоор 1м^2 нь 1.8 сая төгрөг буюу $71,3\text{м}^2 \times 1.8$ сая төгрөг=128.3 сая төгрөг болж байна. Тус байрыг тохижилтгүй хүлээн авсан бөгөөд 14.2 сая төгрөгийн илүү үнээр худалдан авсан байна.
 - Мөн 2020 онд хэрэгжсэн хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт тохижилтын ажлуудыг чанаргүй гүйцэтгэх нь төсвийн хөрөнгийг үр өгөөж муутай, дахин засварлагдах хэмжээнд хүргэсэн байна.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн хөрөнгийг зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн төлөвлөн худалдан авах, гэрээний биелэлтийг хангуулж ажилласнаар төсвийн зардлыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх боломж байсан байна.

3.7. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж зөрчлийг арилгасан уу?

2019 оны хөрөнгө оруулалтын аудитаар дүүргүүдэд төлөвлөлт, санхүүжилт, ХАА, захиалагчийн хяналттай холбоотой 5 зөвлөмж, БЗД, ХУД, СХД-үүдэд ХАА-нд 958.1 сая төгрөгийн 3, ЧД-т санхүүжилт илүү шилжүүлсэн 97.1 сая төгрөгийн 1 зөрчил арилгах, нийт 4 албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

Албан шаардлага: ХУД, БЗД албан шаардлагын биелүүлж ажилласан. Харин ЧД, СХД албан шаардлагын биелэлтийг ирүүлээгүй, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 17. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт

№	Дүүргийн нэр	Зөвлөмж		Албан шаардлага			
		Өгсөн /тоо/	Биелсэн /тоо/	Өгсөн /тоо/	Дүн	Биелсэн /тоо/	Дүн
1	БЗД	5	-	1	458.1	1	458.1
2	СХД	5	-	1	255		
3	ХУД	5	-	1	245	1	245
4	ЧД	5	-	1	97.1		
5	БГД	5	-				
6	БНД	5	-				
7	НД	5	-				
8	СБД	5	-				
	Нийт	5	-	4	1 055.2	2	703.1

Зөвлөмж: Биелэлтийг дүүргүүдээс ирүүлсэн ч биелэлт хангалтгүй, зөрчил дахин давтагдаж байна.

Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нь тухайн үед ажил хариуцаж байсан албан хаагчид ажлаас чөлөөлөгдсөн, ажлын уялдаа холбоогүй, залгамж чанар алдагдсантай холбоотой байна.

Дүгнэлт: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчил дахин давтагдаж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө ЭЗНХҮЧ, ЗДМХ-т тусгагдаагүй, зураг төсөв, ТЭЗҮ, газрын зөвшөөрөлгүй ТАХ төлөвлөж батлуулсан.
2. Хэрэгжих боломж бүрдээгүй ажлыг төлөвлөснөөс гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хугацаа хойшлогдох, ажил гүйцэтгэх явцад хүндрэл бэрхшээл үүсэх, төлөвлөсөн ажил хэрэгжихгүйд хүрэх, хөрөнгө оруулалтад батлагдсан төсөв зарцуулагдахгүй үлдэх зэрэг үр дагаврыг бий болгосон.
3. ХАА зохион байгуулах явцад илэрсэн зөрчил нь ХАА-ны өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж байна.
4. Захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, ажлыг дутуу болон чанаргүй гүйцэтгүүлсэн, чанарын шаардлага хангаагүй хөрөнгө нийлүүлснээс шалтгаалж зарим техник тоног төхөөрөмж нь ашиглалтын шаардлага хангалтгүй.
5. ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа боловч тухай ажил үйлчилгээ нь чанарын болоод хуулийн шаардлагад нийцсэн эсэхэд анхаарал хандуулахгүй, хугацаа хэтэрсэн гүйцэтгэл дээр алдангийг үнэн бодитоор тооцохгүй байгаа зэрэг нь санхүүгийн сахилга бат сул байгааг харуулж байна.
6. Төлөвлөж, баталсан нийт ТАХ-ний 87.9%-ийг хэрэгжүүлсэн ч 41.6% нь төлөвлөлттэй холбоотой, 35.1% нь ХАА зохион байгуулахтай холбоотой, 17.9% нь шаардлага хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан, 16.1% нь захиалагчийн хяналттай холбоотой зөрчил тус тус илэрсэн.
7. ТАХ-ний төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчил жил бүр давтагдаж арилахгүй байгаа нь үнэлгээний хороо, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага, албан тушаалтан, ашиглалтад хүлээн авах комисс, хяналт тавьж буй ИТХ, ЗД, төрийн албан тушаалтнууд хууль тогтоомж дүрэм журмыг мөрдөхгүй хариуцсан ажилдаа хайнга, хариуцлагагүй ханддагтай холбоотой байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Дүүргүүдийн ИТХ-д:

1. Хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу ТАХ-ний төлөвлөлтийг хийж, батлах;
2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дах заалтын шаардлага хангасан ТАХ-г төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр батлах;
3. Хөрөнгө оруулалтын ТАХ-нд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх.

Дүүргийн Засаг дарга болон худалдан авах ажиллагааны албаны дарга нарт:

1. Хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу ТАХ-ний төлөвлөлтийг батлуулах;
2. ХАА-ны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримтлан бараа болон ажлын онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтүүдийг ТББ-т тусгаж, шаардлага хангасан гүйцэтгэгч сонгон шалгаруулах;
3. Захиалагчийн хяналтыг хангалтгүй, үр дүн муутай хэрэгжүүлсэн нь төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжид муугаар нөлөөлж байгааг анхаарч хяналтыг мэргэжлийн ажилтнууд, эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх;
4. ТАХ-г чанарын хувьд ашиглалтын шаардлага хангахуйц түвшинд гүйцэтгүүлэх, ажлын тоо хэмжээ дутуу болон чанаргүй хийсэн ажлуудыг гүйцэтгэгчдээр дахин хийлгүүлэх;
5. ТАХ-ний төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчил жил бүр давтагдаж арилахгүй байгаад анхаарал хандуулж төлөвлөлт, үнэлгээний хороо, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн, байгууллага, албан тушаалтан, ашиглалтад хүлээн авах комисс, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг эрс сайжруулж, цаашид давтан гаргахгүй байж зөрчлийг таслан зогсоох.

Холбогдох байгууллагын санал

**НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**


Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1 дүгээр хороо, Наран хороолол,
Нацагдоржийн гудамж 58, 12090
Утас/Факс: (976) 7021-0017, 7021-0330
http://bnd.ub.gov.mn

2021.05.06 № 03/130
таний 2021.04.30 -ны № 865 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Илэрсэн зөрчлийг дахин давтахгүй байхад анхаарч ажиллах болно.



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
13 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө-57, 13330
Утас/Факс: (976-51) 26-63-59
http://www.bzd.ub.gov.mn

2021.05.05 № 02/164
таний 2021.04.30 -ны № 864 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

Тус дүүрэгт хэрэгжүүлсэн "2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл болон сонсох ажиллагааны мэдэгдэлтэй танилцлаа. Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.

Цаашид тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА  И-БАТТӨГС


**СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Дөнөөрийн гудамж-13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14190
Утас: (976) 7007-0109
E-mail: info@sbd.gov.mn
http://www.sbd.ub.gov.mn

2021.05.05 № 3/489
таний 2021.04.30 -ны № 868 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн 2020 оны хөрөнгө оруулалтын ажилд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл болон сонсох ажиллагааны мэдэгдэлтэй танилцлаа. Өгсөн зөвлөмжүүдийг мөрдөж ажиллах болно.



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
4 дүгээр хороо, Замдрын гудамж 3, 16052
Утас: 7012-0320, Факс: 7012-3132
E-mail: info@bgd.mn
http://www.bgd.mn

2021.05.10 № 03/915
таний 2021.04.30 -ны № 868 -т

НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.

ДАРГА  Б.НАРАНГЭРЭЛ

**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Баянголын гудамж-1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: 7017-0109
<http://www.shd.mn>

2021.05.05	№	03/910
таний	2021.04.30	-ны № 868 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020 оны хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020 онд шинээр болон дамжин хэрэгжсэн ажлуудыг бодлогын баримт бичигт тусгасан талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Цаашид аудитын тайланд дурдсан алдаа, зөрчлийг гаргахгүй байхад анхаарч ажиллах болно.

Хавсралт 2 хуудастай.

**НИЙСЛЭЛИЙН
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж, 15170
Утас: (976) 7777-1992, Факс: (976-11) 31-02-04
E-mail: info@chingeltai.gov.mn

2021.05.05	№	3/661
таний	2021.04.30	-ны № 868 -т

Хариу хүргүүлэх тухай

“Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн тайлангийн төсөлтэй танилцаж, дараах тайлбарыг хүргүүлж байна.

1. “Дүүргийн спорт цогцолборт шаардлагатай тоног төхөөрөмж” бэлтгэн нийлүүлэх гэрээний хувьд “Компас саллай” ХХК нь ажил хүлээлцэх, комисс ажиллуулах тухай албан хүсэлтээ гэрээний хүчинтэй байх хугацаанд ирүүлсэн бөгөөд ажил хүлээлцэх комисс 4 хоногийн дараа ажилласан нь гэрээнд заасны дагуу алданги тооцох үндэслэл болохгүй гэж үзсэн болно.

2. “Тэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж” бэлтгэн нийлүүлэх гэрээний дагуу компани нь цар тахлын улмаас олон улсын тээвэр зууч саатсантай холбоотойгоор алданги тооцохгүй байхыг хүссэн албан бичгийг ирүүлсэн нь давагдашгүй хүчин зүйл гэж үнэлэх боломжтой байна.

Гүйцэтгэлийн тайланд өөр саналгүй бөгөөд зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах болно.

**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Иргэздэд үйлчлэх төв байр, Чингэлтэй дүүрэг, 20 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042
Утас: 7777-1965, Факс: (976-11) 34-44-77
E-mail: info@khanuul.mn
<http://www.khanuul.mn>

2021.05.06	№	06/626
таний	2021.04.20	-ны № 868 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт.... хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮНГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБАЯР

Саналд өгсөн тайлбар

БЗД, БГД, БНД, СБД-ийн ЗДТГ-аас тайлангийн төсөлтэй тусгуулах саналгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

ХУД, ЧД, СХД-ийн ЗДТГ-аас албан бичгээр 8 санал ирүүлсэн. Үүнээс 3 саналыг хүлээн авч тайланд холбогдох өөрчлөлтийг хийсэн.

	Ирүүлсэн санал	Саналыг хүлээн авсан эсэх	НТАГ-ын тайлбар
ХУД-ийн ЗДТГ-аас 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн 06/626 дугаартай албан бичиг			
1	“Замын индүү худалдан авах” ажил. Гэрээний дүн:88.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жеопро Монголиа ХХК. 2020 оны 6 дугаар сард нийлүүлэгдсэн. 2 сар ашигласан. Техникийн үзүүлэлт, арлын дугаар нь тодорхойгүй. Мотор хөлөрч, 4 дугуй нимгэрч язарсан байдалтай байсан. Зөрчлийг арилгасан талаар санал ирүүлсэн.	Тийм	Аудитаар өгсөн үүрэг даалгаварын дагуу зөрчлийг арилгасан гэж тайланд тусгав.
2	Нисэх яармагт дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажил. Гэрээний дүн: 678.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Чингисийн отог ХХК, ОАКС экспресс ХХК. Цаашид зөрчлийг арилгах талаар анхаарч ажиллах санал ирүүлсэн.	Үгүй	Зөрчил арилаагүй.
3	2020 оны хэрэгжүүлэхээр жагсаалтад батлагдсан ТАХ-ний 36.5 % нь дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй бүрэн уялдаагүй байна. 18 ТАХ уялдсан тул өөрчлөлт оруулах санал ирүүлсэн.	Тийм	Хүснэгт 3-т тусгагдсан 27 ТАХ гэснийг 13 ТАХ гэж өөрчиллөө.
4	“Ахмадын хөгжлийн төвийн орон сууц худалдан авах” ажил. Гэрээний дүн:142.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Моншике ХХК. Ажлын тоо хэмжээнд тусгагдсан чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй байсан. Зах зээлийн үнийн дагуу худалдан авсан гэсэн санал ирүүлсэн.	Үгүй	Ажлын тоо хэмжээнд тусгагдсан чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй тул саналыг хүлээн аваагүй.
5	ХАА-г зохион байгуулахад гарсан зөрчил, ТАХ-ны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой гарсан зөрчлүүдтэй холбоотой санал.	Үгүй	Архивын баримтад дутуу бүрдүүлсэн холбогдох баримтыг нөхөн бүрдүүлж ирүүлсэн. учир саналыг хүлээн аваагүй.
ЧД-ийн ЗДТГ-аас 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн 03/661 дугаартай албан бичиг			
6	“Дүүргийн спорт цогцолборт шаардлагатай тавилга тоног төхөөрөмж” ажлын гэрээний тусгай нөхцөлийн 17.1 дэх заалтыг үндэслэн “Компас саплай” ХХК-д хугацаа хэтэрсэн 4 хоногийн алдангийг тооцох боломгүй гэсэн санал ирүүлсэн.	Үгүй	Комисс ажиллуулах мэдэгдэл хүргүүлсэн албан тоот байхгүй учир саналыг хүлээн аваагүй.
7	“Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж” ажлын гэрээний тусгай нөхцөлийн 9.1 дэх заалтыг үндэслэн “Онцгой Өргөө” ХХК-д хугацаа хэтэрсэн 38 хоногийн алдангийг тооцох боломгүй гэсэн санал ирүүлсэн.	Үгүй	Ачаа бараа хил, гааль дээр саатсан талаар тодорхойлох баримт материал байхгүй учир саналыг хүлээн аваагүй.
СХД-ийн ЗДТГ-аас 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 03/910 дугаартай албан бичиг			
8	2020 онд хэрэгжүүлэхээр жагсаалтад батлагдсан ТАХ-нууд нь дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөртэй бүрэн уялдаагүй байна.	Тийм	Хүснэгт 3-т тусгагдсан 19 ТАХ гэснийг 15 ТАХ гэж өөрчиллөө.

Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй ТАХ

№	Дүүрэг нэр	Батлагдсан төсөл, арга хэмжээний нэр	Сүүлийн тодотгол		ЭЗНХҮЧ туссан эсэх	
			Тогтоолын огноо	Төсөвт өртөг	Тийм/үгүй	Заалтын дугаар
1	БЗД	Баянзүрх дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст автомашин нийлүүлэх /Бараа/	2020.11.25 №06	4.00	үгүй	-
2	БЗД	Цэргийн төв эмнэлгийн хүүхдийн тасгийн 61, 62-р өрөөний урсгал засварын ажил /Ажил/	2020.11.25 №06	5.82	үгүй	-
3	БЗД	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэст автомашин нийлүүлэх /Бараа/	2020.11.25 №06	33.50	үгүй	-
4	БЗД	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн барилгын засварын ажил /Ажил/ түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	115.09	үгүй	-
5	БЗД	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвд хүүхдийн өрөөний тавилга, эд хогшил нийлүүлэх /Бараа/	2020.11.25 №06	2.00	үгүй	-
6	БЗД	Дүүргийн гэр хороолол болон орон сууцны хорооллын гудамж талбайн хаягжуулалтын ажил /Ажил/ түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	100.00	үгүй	-
7	БЗД	БЗД-ийн 20-р хорооны ерөнхий төлөвлөгөө	2020.11.25 №06	300.00	үгүй	-
8	БЗД	БЗД-ийн авто баазын камержуулалтын ажил /Ажил/ түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	22.30	үгүй	-
9	БЗД	Баянзүрх дүүргийн авто баазын хашааны ажил /Ажил/	2020.11.25 №06	30.00	үгүй	-
10	БЗД	Баянзүрх дүүрэгт өөрөө буулгагч ачааны машин худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	200.00	үгүй	-
11	БЗД	Баянзүрх дүүрэгт усны авто машин /дунд оврын/ худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	50.00	үгүй	-
12	БЗД	Баянзүрх дүүрэгт бага оврын ковш худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	50.00	үгүй	-
13	БЗД	Баянзүрх дүүргийн НҮГ-т хог тээврийн машин худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	300.00	үгүй	-
14	БЗД	Баянзүрх дүүрэгт суудлын авто машин худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	60.00	үгүй	-
15	БЗД	Баянзүрх дүүрэгт ачааны авто машин /давхар кабинтай/ худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	29.50	үгүй	-
16	БЗД	Баянзүрх дүүрэгт хагас ачааны микро автобус худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	39.50	үгүй	-
17	БЗД	Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн барилгын засварын ажил /Ажил/ түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	190.00	үгүй	-
18	БЗД	Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн барилгын засварын ажил	2020.11.25 №06	189.00	үгүй	-
19	БЗД	Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв боловсруулах	2020.11.25 №06	84.58	үгүй	-
20	БЗД	Баянзүрх дүүргийн Иргэний анхан шатны шүүх байгууллагын өрөөний тохижилт	2020.11.25 №06	21.00	үгүй	-
21	БЗД	Баянзүрх дүүргийн 45-р цэцэрлэгийн дээврийн засварын ажил	2020.11.25 №06	14.12	үгүй	-
22	БЗД	Дүүргийн нутаг дэвсгэрт ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажил	2020.11.25 №06	370.00	үгүй	-
23	БЗД	Баянзүрх дүүргийн 7 дугаар хороонд хийгдэх гадна хяналтын камерын ажил /Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/ /Ажил/	2020.11.25 №06	53.15	үгүй	-
24	БЗД	БЗД-ийн Тамгын газрын төр захиргааны төв байрны засварын ажил	2020.11.25 №06	113.80	үгүй	-
25	БЗД	БЗД-ийн 18 дугаар хороо 13-р байрны барилгын дээврийн засварын ажил	2020.11.25 №06	75.74	үгүй	-

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

26	БЗД	БЗД-ийн Прокурорын байгууллагад авто машин худалдан авах	2020.11.25 №06	43.00	үгүй	-
27	БЗД	БЗД-ийн 3, 5, 7, 9, 13, 14, 15, 21, 22, 26-р хороодын барилгын засварын ажил	2020.11.25 №06	327.17	үгүй	-
28	БЗД	БЗД-ийн 12, 18, 19, 24, 25, 28-р хороодын цогцолбор байрны засварын ажил	2020.11.25 №06	147.99	үгүй	-
29	БЗД	Шижир амралтын засварын ажил	2020.11.25 №06	250.00	үгүй	-
30	БЗД	Татварын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил	2020.11.25 №06	300.00	үгүй	-
31	БГД	Баянгол дүүргийн замын цагдаагийн хэлтсийн барилгын гадна тохижилтын ажил	2020.12.18 №03/01	50.00	үгүй	-
32	БГД	Баянгол дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд компьютер, тоног төхөөрөмж худалдан авах ажил	2020.12.18 №03/01	130.00	үгүй	-
33	БГД	Баянгол дүүргийн орон сууцны хороололд хог ангилан ялгах хогийн сав суурилуулах ажил	2020.12.18 №03/01	480.00	үгүй	-
34	БГД	"Баянгол дүүргийн Түрээсийн орон сууцны барилгын ажил"	2020.12.18 №03/01	1,920.00	үгүй	-
35	БГД	"Дүүргийн сурталчилгааны лед дэлгэц суурилуулах ажил"	2020.12.18 №03/01	210.00	үгүй	-
36	БГД	"Баянгол дүүрэгт зөөврийн хогийн сав худалдан авах ажил"	2020.12.18 №03/01	60.00	үгүй	-
37	БГД	"Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах ажил" БГД-ХААА/ОН-20-22	2020.12.18 №03/01	50.00	үгүй	-
38	БГД	"Баянгол дүүргийн Архивын тоног төхөөрөмж, тавилга худалдан авах ажил" БГД-ХААА/ОН-20-02	2020.12.18 №03/01	200.00	үгүй	-
39	БГД	Баянгол дүүргийн Архивын барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил	2020.12.18 №03/01	400.00	үгүй	-
40	БГД	Тохижилт бүтээн байгуулалтын зураг төслийн ажил	2020.12.18 №03/01	220.00	үгүй	-
41	БГД	Баянгол хүүхдийн зуслангийн цогцолбор барилгын нэмэлт ажил	2020.12.18 №03/01	200.00	үгүй	-
42	БГД	15,16,17,18,19,20,21,22,23 дугаар хороодын цогцолбор байрны барилгын их засвар	2020.12.18 №03/01	106.10	үгүй	-
43	БГД	Баянгол дүүргийн замын цагдаагийн хэлтсийн гадна дулааны шугам сүлжээний нэмэлт ажил	2020.12.18 №03/01	39.80	үгүй	-
44	БГД	Баянгол дүүргийн 14 дүгээр хорооны иргэний танхимын өргөтгөлийн нэмэлт ажил	2020.12.18 №03/01	35.95	үгүй	-
45	БГД	Зураг төслийн ажил	2020.12.18 №03/01	50.00	үгүй	-
46	БГД	Баянгол дүүргийн түрээсийн орон сууцны газар шороо суурийн ажил	2020.12.18 №03/01	80.00	үгүй	-
47	СХД	Газар чөлөөлөлтөд орсон иргэн С.Даваадоржийн Трансформаторыг худалдан авах /26-р хороо/	2020.11.19 №02/04	43.80	үгүй	-
48	СХД	Авто замын зорчих хэсгийг өргөтгөх /13-р хороо, 9-р байрны хойд тал/	2020.11.19 №02/04	40.00	үгүй	-
49	СХД	Хот тохижилтын тусгай зориулалтын техник хэрэгсэл, машин механизм	2020.11.19 №02/04	250.00	үгүй	-
50	СХД	Гоёлын гэрэлтүүлэг	2020.11.19 №02/04	150.00	үгүй	-
51	СХД	Эрчим хүчний хүчдэл сайжруулах /21 дүгээр хороо/	2020.11.19 №02/04	100.00	үгүй	-
52	СХД	Гүний худаг барих /21 дүгээр хороо/	2020.11.19 №02/04	50.00	үгүй	-
53	СХД	11-р хорооны "Гурван тэрх" ӨЭМТ-д авто машин худалдан авах	2020.11.19 №02/04	20.00	үгүй	-
54	СХД	19 дүгээр хорооны 90 дүгээр байрны халаалт болон халуун хүйтэн усны хэрэгцээ хангамжийг нэмэгдүүлэх засвар	2020.11.19 №02/04	9.00	үгүй	-
55	СХД	Цэцэрлэгт хүрээлэнгийн Номын сан барих /2-р хороо/	2020.11.19 №02/04	155.00	үгүй	-
56	СХД	Цэцэрлэгт хүрээлэнгийн Номын сан барих /19-р хороо/	2020.11.19 №02/04	30.00	үгүй	-
57	СХД	Тээвэрлэлт үйлчилгээний төвийн засварын байр, граш, сургалтын төв барихад дэмжлэг	2020.11.19 №02/04	40.00	үгүй	-
58	СХД	Автобусны буудал шинээр барих	2020.11.19 №02/04	150.00	үгүй	-
59	СХД	Номын сангийн тохижилт, номын фондын баяжилт /2-р хороо/	2020.11.19 №02/04	30.00	үгүй	-
60	СХД	Газар чөлөөлөх нөхөн олговор олгох	2020.11.19 №02/04	300.00	үгүй	-
61	СХД	Хөрөнгө оруулалтын ажлуудын зураг, төсөв боловсруулах	2020.11.19 №02/04	500.00	үгүй	-

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

62	ХУД	зураг төсөв	2020.12.11 №10	200.00	үгүй	-
63	ХУД	Анхан шатны шүүхийн барилгын гадна фасадын засвар	2020.12.11 №10	80.00	үгүй	-
64	ХУД	Нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилт	2020.12.11 №10	432.00	үгүй	-
65	ХУД	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дуут дохиоллын цамхаг суурилуулах	2020.12.11 №10	90.00	үгүй	-
66	ХУД	Гүний худаг байгуулах	2020.12.11 №10	30.00	үгүй	-
67	ХУД	Хуучин байрны орцны засвар, үйлчилгээ	2020.12.11 №10	20.00	үгүй	-
68	ХУД	Эрүүл мэндийн төвийн засвар	2020.12.11 №10	50.00	үгүй	-
69	ХУД	Гудамж, зам талбайн тохижилт	2020.12.11 №10	50.00	үгүй	-
70	ХУД	Хорооны байрны зоорины давхрыг тохижуулах	2020.12.11 №10	40.00	үгүй	-
71	ХУД	Гудамж, зам талбайн засвар, тохижилтын ажил	2020.12.11 №10	150.00	үгүй	-
72	ХУД	Хорооны байрны дээврийг засварлах	2020.12.11 №10	15.00	үгүй	-
73	ХУД	Ажилчны цагаан хаалгыг засварлах	2020.12.11 №10	20.00	үгүй	-
74	ХУД	Соёлын ордны засварын ажил	2020.12.11 №10	29.50	үгүй	-
75	ЧД	Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн шуурхай албанд тавилга, машин, тоног төхөөрөмж	2020.11.19 №9	60.00	үгүй	-
76	ЧД	Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газар, эрх зүйн туслалцааны төвийн засвар, тоног төхөөрөмж	2020.11.19 №9	10.00	үгүй	-
77	ЧД	Цагдаагийн 2 дугаар хэлтсийн байцаалтын өрөө болон камерын хяналтын өрөөний засвар тохижилт	2020.11.19 №9	70.00	үгүй	-
78	ЧД	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж	2020.11.19 №9	20.00	үгүй	-
79	ЧД	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газарт шаардлагатай тоног төхөөрөмж	2020.11.19 №9	40.00	үгүй	-
80	ЧД	Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж	2020.11.19 №9	6.10	үгүй	-
81	ЧД	Иргэний бүртгэлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж	2020.11.19 №9	40.00	үгүй	-
82	ЧД	Дүүргийн спорт цогцолборт шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж	2020.11.19 №9	200.00	үгүй	-
83	ЧД	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт автомашин	2020.11.19 №9	68.50	үгүй	-
84	ЧД	Чингэлтэй дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст автомашин	2020.11.19 №9	58.00	үгүй	-
85	ЧД	Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн Жигжидийн тасгийн барилга	2020.11.19 №9	1,000.00	үгүй	-
86	ЧД	19-р хорооны Тахилтын аманд гүний худаг болон гэрэлтүүлгийн гадна цахилгаан хангамжийн 400КВА-гийн иж бүрэн дэд өртөө барих ажил	2020.11.19 №9	97.00	үгүй	-
87	БНД	Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд автомашин худалдан авах /Шүүх, Улсын бүртгэл, ЗДТГ, Багануур-Ус ААТҮГазарт/ Багц-2	2020.11.25 №07	80.00	үгүй	-
88	БНД	Төрийн байгууллагуудад компьютер, техник хэрэгсэл, эд хөрөнгө худалдан авах	2020.11.25 №07	50.00	үгүй	-
89	БНД	Дүүргийн авто замын засвар шинэчлэлтийн зураг төсөв боловсруулах	2020.11.25 №07	50.00	үгүй	-
90	БНД	Багануур тохижилт ОНӨААТҮГ-т автобус худалдан авах	2020.11.25 №07	50.00	үгүй	-
91	БНД	Багануур Дулааны станц ТӨХК-д шуурхай ажиллагааны авто машин худалдан авах	2020.11.25 №07	35.00	үгүй	-
92	БНД	ЭМТөвийн өмнөх усан оргилуурыг засварлах материал худалдан авах	2020.11.25 №07	8.00	үгүй	-
93	БНД	Төв талбайн лед дэлгэцийг засварлах материал худалдан авах	2020.11.25 №07	10.00	үгүй	-
94	БНД	Усан спорт боулингийн төвд насос 2ш худалдан авах	2020.11.25 №07	6.00	үгүй	-
95	БНД	Дүүргийн төв зам дагуух гэрлэн дохионы зураг төсөв боловсруулах	2020.11.25 №07	2.00	үгүй	-
96	БНД	23, 9 дүгээр байрнуудын гадна фасад засварын зураг төсөл, төсөв боловсруулах	2020.11.25 №07	10.00	үгүй	-
97	БНД	13-18 дугаар байр, 19- 23 дугаар байрнуудын дундах тохижилтын зураг төсөл, төсөв боловсруулах	2020.11.25 №07	10.00	үгүй	-

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

98	БНД	132-р цэцэрлэгийн дээврийн засварын зураг төсөв боловсруулах	2020.11.25 №07	2.00	үгүй	-
99	БНД	Ахмадын хөгжлийн төвийн барилгын зураг төсөл, төсөв боловсруулах	2020.11.25 №07	10.00	үгүй	-
100	НД	Усалгааны машин 10 тн	2020.11.25 №02/02	96.00	үгүй	-
101	НД	Боб кат	2020.11.25 №02/02	143.50	үгүй	-
102	НД	Хогны машин	2020.11.25 №02/02	68.75	үгүй	-
103	НД	75 дугаар байрны халуун усны бойлер худалдан авч, угсарч суурилуулах ажил	2020.11.25 №02/02	25.00	үгүй	-
104	НД	Ахмадын сувилалд тавилга эд хогшил худалдан авах ажил	2020.11.25 №02/02	5.00	үгүй	-
105	НД	Гэрэлтүүлгийн материал худалдан авах	2020.11.25 №02/02	66.00	үгүй	-
106	НД	Цэргийн ангид иж бүрэн үлээвэр хөгжим	2020.11.25 №02/02	18.00	үгүй	-
107	НД	7 Бүтэн сийлбэртэй гэр худалдан авах	2020.11.25 №02/02	20.00	үгүй	-
108	БХД	Зураг төсөв, магадлал	2020.11.18 А/06	4,00	үгүй	-
109	СБД	2-р хорооны ӨЭМТ, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр шинээр барих	2019.11.25 №03	600.0	үгүй	-
110	СБД	7-р хорооны ӨЭМТ, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр шинээр барих	2019.11.25 №03	600.0	үгүй	-
111	СБД	12-р хороонд цэцэрлэг барих	2019.11.25 №03	1,900.00	үгүй	-
112	СБД	Эрүүл мэндийн төвд Цахим эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2019.11.25 №03	49.30	үгүй	-
113	СБД	Дүүргийн 19 дүгээр хорооны байрны засвар хийх	2019.11.25 №03	69.00	үгүй	-
114	СБД	Дүүргийн 1-20 дугаар хорооны байрны гадна хаягжуулалт хийх	2019.11.25 №03	70.00	үгүй	-
115	СБД	Дүүргийн 16-р хорооны байрыг гадна цэвэр усны шугамд холбох	2019.11.25 №03	19.80	үгүй	-
116	СБД	248-р цэцэрлэгийн эдэлбэр газарт тохижилт хийх	2019.11.25 №03	100.00	үгүй	-
117	СБД	29-р тусгай дунд сургуулийн эдэлбэр газарт хөл бөмбөгийн талбай байгуулах	2019.11.25 №03	133.90	үгүй	-
118	СБД	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих	2019.11.25 №03	16,000.00	үгүй	-
119	СБД	143-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих	2019.11.25 №03	1,313.00	үгүй	-
120	СБД	143-р цэцэрлэгийн өргөтгөлд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж худалдан авах	2019.11.25 №03	468.67	үгүй	-
121	СБД	Дүүргийн 13 дугаар хорооны цогцолбор барилгыг цэвэр усны шугамд холбох	2019.11.25 №03	50.00	үгүй	-
122	СБД	Дүүргийн 8 дугаар хорооны 34 дүгээр байрны лифт засварлах	2019.11.25 №03	18.00	үгүй	-
123	СБД	58 дугаар сургуулийн хичээлийн 1, 2 дугаар байрыг холбосон хүзүүвч барих	2019.12.16 №05	151.14	үгүй	-
124	СБД	Бэлхэд Цагдаагийн 2 дугаар хэлтсийн пост барих	2019.12.16 №05	140.00	үгүй	-
125	СБД	2 дугаар цэцэрлэгийн сантехникийн засвар хийх	2019.12.16 №05	94.35	үгүй	-
126	СБД	4 дүгээр сургуулийн сантехникийн засвар хийх	2019.12.16 №05	188.11	үгүй	-
127	СБД	4 дүгээр сургуулийн урлаг заалны засвар хийх	2019.12.16 №05	100.00	үгүй	-
128	СБД	31 дүгээр сургуулийн цонхны засвар хийх	2019.12.16 №05	49.64	үгүй	-
129	СБД	31 дүгээр сургуулийн спорт талбайн тохижилт хийх	2019.12.16 №05	50.00	үгүй	-
130	СБД	58 дугаар сургуулийн спорт талбайн тохижилт хийх	2019.12.16 №05	50.00	үгүй	-
131	СБД	130 дугаар цэцэрлэгийн А байрны дотор засвар хийх	2019.12.16 №05	57.98	үгүй	-
132	СБД	130 дугаар цэцэрлэгийн А байрны сантехникийн засвар хийх	2019.12.16 №05	59.28	үгүй	-
133	СБД	130 дугаар цэцэрлэгийн А байрны цахилгааны засвар хийх	2019.12.16 №05	44.85	үгүй	-

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

134	СБД	11 дүгээр хороо, Өрхийн эрүүл мэндийн төвийн дотор засвар хийх	2019.12.16 №05	42.32	үгүй	-
135	СБД	14 дүгээр хороо, Өрхийн эрүүл мэндийн төвийн сантехник, цахилгааны засвар хийх	2019.12.16 №05	53.13	үгүй	-
136	СБД	Дүүргийн 16, 18-р хорооны байр, 1 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн байрны гадна фасад засвар хийх	2019.12.16 №05	59.93	үгүй	-
137	СБД	Дүүргийн Прокурорын барилгын засвар хийх	2019.12.16 №05	50.00	үгүй	-
138	СБД	Дүүргийн 6, 31, 35, 58, 71 дүгээр сургуулиудад сургалтын самбар худалдан авах	2019.12.16 №05	100.00	үгүй	-
139	СБД	Дүүргийн 51-р цэцэрлэгт 1, 2 дугаар хоолны тогоо худалдан авах	2019.12.16 №05	11.00	үгүй	-
140	СБД	Дүүргийн Онцгой байдлын хэлтэс шуурхай албаны автомашин худалдан авах	2019.12.16 №05	35.00	үгүй	-
141	СБД	Дүүргийн Замын цагдаагийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2019.12.16 №05	24.35	үгүй	-
142	СБД	Дүүргийн Замын цагдаагийн хэлтэст шаардлагатай тавилга худалдан авах	2019.12.16 №05	25.64	үгүй	-
143	СБД	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2019.12.16 №05	43.03	үгүй	-
144	СБД	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газарт шаардлагатай тавилга худалдан авах	2019.12.16 №05	23.75	үгүй	-
145	СБД	Дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2019.12.16 №05	192.40	үгүй	-
146	СБД	Дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэст шаардлагатай тавилга худалдан авах	2019.12.16 №05	127.60	үгүй	-
147	СБД	Дүүргийн Засаг даргын Тамгын газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2019.12.16 №05	9.90	үгүй	-
148	СБД	Дүүргийн Боловсролын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2019.12.16 №05	11.65	үгүй	-
149	СБД	Дүүргийн Статистикийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2019.12.16 №05	9.76	үгүй	-
150	СБД	Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвд шаардлагатай үйлдвэрийн зориулалттай тусгай тоног төхөөрөмж худалдан авах	2019.12.16 №05	30.00	үгүй	-
Дүн				36,530.21		
№	Дүүрэг нэр	Батлагдсан төсөл, арга хэмжээний нэр	Тодотгол сүүлийнх		ЗДМХ туссан эсэх	
			тогтоолын огноо	Төсөвт өртөг	Тийм/үгүй	Заалтын дугаар
1	БЗД	Баянзүрх дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст автомашин нийлүүлэх /Бараа/	2020.11.25 №06	43.00	үгүй	-
2	БЗД	Цэргийн төв эмнэлгийн хүүхдийн тасгийн 61, 62-р өрөөний урсгал засварын ажил /Ажил/	2020.11.25 №06	5.82	үгүй	-
3	БЗД	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэст автомашин нийлүүлэх /Бараа/	2020.11.25 №06	33.50	үгүй	-
4	БЗД	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн барилгын засварын ажил /Ажил/ /түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	115.09	үгүй	-
5	БЗД	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвд хүүхдийн өрөөний тавилга, эд хогшил нийлүүлэх /Бараа/	2020.11.25 №06	2.00	үгүй	-
6	БЗД	Дүүргийн гэр хороолол болон орон сууцны хорооллын гудамж талбайн хаягжуулалтын ажил /Ажил/ /түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	100.00	үгүй	-
7	БЗД	БЗД-ийн 20-р хорооны ерөнхий төлөвлөгөө	2020.11.25 №06	300.00	үгүй	-
8	БЗД	БЗД-ийн авто баазын камержуулалтын ажил /Ажил/ /түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	22.30	үгүй	-
9	БЗД	Баянзүрх дүүргийн авто баазын хашааны ажил /Ажил/	2020.11.25 №06	30.00	үгүй	-
10	БЗД	Баянзүрх дүүрэгт өөрөө буулгагч ачааны машин худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	200.00	үгүй	-
11	БЗД	Баянзүрх дүүрэгт усны авто машин /дунд оврын/ худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	50.00	үгүй	-
12	БЗД	Баянзүрх дүүрэгт бага оврын ковш худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	50.00	үгүй	-

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

13	БЗД	Баянзүрх дүүргийн НҮГ-т хог тээврийн машин худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	300.00	үгүй	-
14	БЗД	Баянзүрх дүүрэгт суудлын авто машин худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	60.00	үгүй	-
15	БЗД	Баянзүрх дүүрэгт ачааны авто машин /давхар кабинтай/ худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	29.50	үгүй	-
16	БЗД	Баянзүрх дүүрэгт хагас ачааны микро автобус худалдан авах /Бараа/	2020.11.25 №06	39.50	үгүй	-
17	БЗД	Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн барилгын засварын ажил /Ажил/түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	190.00	үгүй	-
18	БЗД	Баянзүрх дүүргийн 2, 16, 18, 19-р хорооны камержуулалтын ажил /Ажил/түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	64.00	үгүй	-
19	БЗД	БЗД-ийн 2, 10-р хороонд хог ангилан ялгах сав нийлүүлэх, тохижуулах ажил /Ажил/түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/	2020.11.25 №06	28.00	үгүй	-
20	БЗД	Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн барилгын засварын ажил	2020.11.25 №06	189.00	үгүй	-
21	БЗД	Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв боловсруулах	2020.11.25 №06	84.58	үгүй	-
22	БЗД	Баянзүрх дүүргийн Иргэний анхан шатны шүүх байгууллагын өрөөний тохижилт	2020.11.25 №06	21.00	үгүй	-
23	БЗД	Баянзүрх дүүргийн 45-р цэцэрлэгийн дээврийн засварын ажил	2020.11.25 №06	14.12	үгүй	-
24	БЗД	Дүүргийн нутаг дэвсгэрт ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажил	2020.11.25 №06	370.00	үгүй	-
25	БЗД	Баянзүрх дүүргийн 7 дугаар хороонд хийгдэх гадна хяналтын камерын ажил /Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/ /Ажил/	2020.11.25 №06	53.15	үгүй	-
26	БЗД	БЗД-ийн Тамгын газрын төр захиргааны төв байрны засварын ажил	2020.11.25 №06	113.80	үгүй	-
27	БЗД	БЗД-ийн 18 дугаар хороо 13-р байрны барилгын дээврийн засварын ажил	2020.11.25 №06	75.74	үгүй	-
28	БЗД	БЗД-ийн Прокурорын байгууллагад авто машин худалдан авах	2020.11.25 №06	43.00	үгүй	-
29	БЗД	БЗД-ийн 3, 5, 7, 9, 13, 14, 15, 21, 22, 26-р хороодын барилгын засварын ажил	2020.11.25 №06	327.17	үгүй	-
30	БЗД	БЗД-ийн 12, 18, 19, 24, 25, 28-р хороодын цогцолбор байрны засварын ажил	2020.11.25 №06	147.99	үгүй	-
31	БЗД	Шижир амралтын засварын ажил	2020.11.25 №06	250.00	үгүй	-
32	БЗД	Татварын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил	2020.11.25 №06	300.00	үгүй	-
33	БГД	Баянгол дүүргийн замын цагдаагийн хэлтсийн барилгын гадна тохижилтын ажил	2020,12,18 №03/01	50.00	үгүй	-
34	БГД	"Баянгол дүүргийн Түрээсийн орон сууцны барилгын ажил"	2020,12,18 №03/01	1,920.00	үгүй	-
35	БГД	"Дүүргийн сурталчилгааны лед дэлгэц суурилуулах ажил"	2020,12,18 №03/01	210.00	үгүй	-
36	БГД	"Баянгол дүүрэгт зөөврийн хогийн сав худалдан авах ажил"	2020,12,18 №03/01	60.00	үгүй	-
37	БГД	"Засаг даргын Тамгын газарт лед дэлгэц худалдан авах ажил"	2020,12,18 №03/01	50.00	үгүй	-
38	БГД	"Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах ажил" БГД-ХААА/ОН-20-22	2020,12,18 №03/01	50.00	үгүй	-
39	БГД	"Баянгол дүүргийн Архивын тоног төхөөрөмж, тавилга худалдан авах ажил" БГД-ХААА/ОН-20-02	2020,12,18 №03/01	200.00	үгүй	-
40	БГД	"Хүүхэд залуучуудын соёлын ордны тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, хяналтын камер шинэчлэх ажил" БГД-ХААА/ОН-20-05	2020,12,18 №03/01	27.50	үгүй	-
41	БГД	Баянгол дүүргийн Архивын барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил	2020,12,18 №03/01	400.00	үгүй	-
42	БГД	Тохижилт бүтээн байгуулалтын зураг төслийн ажил	2020,12,18 №03/01	220.00	үгүй	-
43	БГД	Зураг төслийн ажил	2020,12,18 №03/01	499.70	үгүй	-
44	БГД	Баянгол дүүргийн замын цагдаагийн хэлтсийн гадна дулааны шугам сүлжээний нэмэлт ажил	2020,12,18 №03/01	39.80	үгүй	-

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

45	БГД	Баянгол дүүргийн 14 дүгээр хорооны иргэний танхимын өргөтгөлийн нэмэлт ажил	2020.12.18 №03/01	35.95	үгүй	-
46	БГД	Зураг төслийн ажил	2020.12.18 №03/01	50.00	үгүй	-
47	БГД	Баянгол дүүргийн түрээсийн орон сууцны газар шороо суурийн ажил	2020.12.18 №03/01	80.00	үгүй	-
48	СХД	Газар чөлөөлөлтөд орсон иргэн С.Даваадоржийн Трансформаторыг худалдан авах /26-р хороо/	2020.11.19 №02/04	43.80	үгүй	-
49	СХД	Зарлан мэдээллийн дуут дохионы цамхаг суурилуулах	2020.11.19 №02/04	50.00	үгүй	-
50	СХД	Тохилог орц /20 дугаар хороо/	2020.11.19 №02/04	50.00	үгүй	-
51	СХД	Хот тохижилтын тусгай зориулалтын техник хэрэгсэл, машин механизм	2020.11.19 №02/04	250.00	үгүй	-
52	СХД	Гоёлын гэрэлтүүлэг	2020.11.19 №02/04	150.00	үгүй	-
53	СХД	Гүний худаг барих /21 дүгээр хороо/	2020.11.19 №02/04	50.00	үгүй	-
54	СХД	11-р хорооны "Гурван тэрх" ӨЭМТ-д авто машин худалдан авах	2020.11.19 №02/04	20.00	үгүй	-
55	СХД	19 дүгээр хорооны 90 дүгээр байрны халаалт болон халуун хүйтэн усны хэрэгцээ хангамжийг нэмэгдүүлэх засвар	2020.11.19 №02/04	9.80	үгүй	-
56	СХД	Цэцэрлэгт хүрээлэнгийн Номын сан барих /2-р хороо/	2020.11.19 №02/04	155.00	үгүй	-
57	СХД	Цэцэрлэгт хүрээлэнгийн Номын сан барих /19-р хороо/	2020.11.19 №02/04	30.00	үгүй	-
58	СХД	Тээвэрлэлт үйлчилгээний төвийн засварын байр, граш, сургалтын төв барихад дэмжлэг	2020.11.19 №02/04	40.00	үгүй	-
59	СХД	Автобусны буудал шинээр барих	2020.11.19 №02/04	150.00	үгүй	-
60	СХД	Амралт цогцолборын газарт амралтын байр барих /21-р хороо/	2020.11.19 №02/04	110.00	үгүй	-
61	СХД	Номын сангийн тохижилт, номын фондын баяжилт /2-р хороо/	2020.11.19 №02/04	30.00	үгүй	-
62	СХД	Газар чөлөөлөх нөхөн олговор олгох	2020.11.19 №02/04	300.00	үгүй	-
63	СХД	Хөрөнгө оруулалтын ажлуудын зураг, төсөв боловсруулах	2020.11.19 №02/04	500.00	үгүй	-
64	ХУД	зураг төсөв	2020.12.11 №10	200.00	үгүй	-
65	ХУД	Иргэд олноор цуглардаг амралт, зугаалгын бүсэд утасгүй интернэтийн сүлжээ суурилуулах	2020.12.11 №10	20.00	үгүй	-
66	ХУД	Цэцэрлэгийн барилга 100 ор	2020.12.11 №10	2,290.13	үгүй	-
67	ХУД	Анхан шатны шүүхийн барилгын гадна фасадын засвар	2020.12.11 №10	80.00	үгүй	-
68	ХУД	Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байрны засвар	2020.12.11 №10	50.00	үгүй	-
69	ХУД	Нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилт	2020.12.11 №10	432.00	үгүй	-
70	ХУД	Шинээр байгуулагдсан хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тавилга, тоног төхөөрөмж	2020.12.11 №10	50.00	үгүй	-
71	ХУД	Замын цагдаагийн хэлтсийн Эргүүлийн авто машин худалдан авах	2020.12.11 №10	30.00	үгүй	-
72	ХУД	Цагдаагийн газрын Эргүүлийн авто машин худалдан авах	2020.12.11 №10	30.00	үгүй	-
73	ХУД	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дуут дохиоллын цамхаг суурилуулах	2020.12.11 №10	90.00	үгүй	-
74	ХУД	Нисэх Яармагт 4 улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах	2020.12.11 №10	268.10	үгүй	-
75	ХУД	11, 12 дугаар хорооны цахилгааны хүчдэл сайжруулах	2020.12.11 №10	154.32	үгүй	-
76	ХУД	Туул голын эрэг дагуу эко зурвас байгуулах	2020.12.11 №10	257.26	үгүй	-
77	ХУД	Таксины зогсоол байгуулах	2020.12.11 №10	30.00	үгүй	-
78	ХУД	Тохижилт, үерийн хамгаалалт хийх / Буянт-Ухаа 23-р гудамж/	2020.12.11 №10	40.00	үгүй	-
79	ХУД	Гүний худаг байгуулах	2020.12.11 №10	30.00	үгүй	-
80	ХУД	Тоглоомын талбай байгуулах	2020.12.11 №10	20.00	үгүй	-
81	ХУД	Явган хүний зам	2020.12.11 №10	20.00	үгүй	-

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

82	ХУД	Хуучин байрны орчны засвар, үйлчилгээ	2020.12.11 №10	20.00	үгүй	-
83	ХУД	Эрүүл мэндийн төвийн засвар	2020.12.11 №10	50.00	үгүй	-
84	ХУД	Гудамж, зам талбайн тохижилт	2020.12.11 №10	50.00	үгүй	-
85	ХУД	Ахмадын хөгжлийн төвийг орон сууц худалдан авч тохижуулах	2020.12.11 №10	200.00	үгүй	-
86	ХУД	Хорооны байрны зоорины давхрыг тохижуулах	2020.12.11 №10	40.00	үгүй	-
87	ХУД	Гудамж, зам талбайн засвар, тохижилтын ажил	2020.12.11 №10	150.00	үгүй	-
88	ХУД	Хорооны байрны дээврийг засварлах	2020.12.11 №10	15.00	үгүй	-
89	ХУД	Ахмадын хөгжлийн төвийг орон сууц худалдан авч тохижуулах	2020.12.11 №10	150.00	үгүй	-
90	ХУД	Сургуулийн хашаа	2020.12.11 №10	40.00	үгүй	-
91	ХУД	Ажилчны цагаан хаалгыг засварлах	2020.12.11 №10	20.00	үгүй	-
92	ХУД	Яармагийн 19-р гудамжны 20 айлыг цэвэр усны шугамд холбох	2020.12.11 №10	50.00	үгүй	-
93	ХУД	Хаягжуулалт	2020.12.11 №10	15.00	үгүй	-
94	ХУД	Жишиг гудамж байгуулах	2020.12.11 №10	30.00	үгүй	-
95	ХУД	Явган хүний зам тавих	2020.12.11 №10	15.00	үгүй	-
